# ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨВИЙН
# 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЭРЭГЛЭГЧИЙН
# ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2020 ОН

# АГУУЛГЫН ТОВЬЁОГ


**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

**УДИРТГАЛ**

Үнэлгээ хийх үндэслэл

Үнэлгээний зорилго

Үнэлгээ судалгааны төрөл:

Үнэлгээ хийх арга зүй

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ**

1.1 Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөл үзүүлэх үйлчилгээнд хийсэн шинжилгээ

1.2. Тусгай утсаар хууль зүйн зөвлөгөө авсан иргэдийн сэтгэл ханамжид хийсэн судалгаа

**ХОЁРДУГААР ХЭСЭГ. БАЙГУУЛЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙХ ШИНЖИЛГЭЭ**

2.1. Байгууллагын чиг үүргийн шинжилгээ

2.2. Байгууллагын дотоод орчны шинжилгээ

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ**

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Бүлэглэсэн түүвэр
Хүснэгт 2. Ажилтны сэтгэл ханамжийн түүвэр
Хүснэгт 3. Үнэлгээг хийх шалгуур үзүүлэлт нь
Хүснэгт 4. Оролцогсдын нас
Хүснэгт 5. Боловсрол
Хүснэгт 6. Ажил эрхлэлтийн байдал
Хүснэгт 7. Ажил эрхлэлтийн байдал * өрхийн орлого
Хүснэгт 8. Ажил эрхлэлтийн байдал ба боловсрол
Хүснэгт 9. Төлбөрийн чадваргүй гэж өөрийгөө тодорхойлсон
Хүснэгт 10. Төлбөрийн чадваргүй гэж өөрийгөө тодорхойлсон ба өрхийн хамаарал
Хүснэгт 11.Мэдээллийг хаанаас авсан бэ
Хүснэгт 12.Өмнөх онуудын харьцуулалт
Хүснэгт 13. Өмгөөллийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байсан
Хүснэгт 14. 3-ээс дээш удаа надтай уулзаж зөвлөгөө өгдөг байсан
Хүснэгт 15. Надад хангалттай мэдээлэл өгдөг байсан
Хүснэгт 16. Мэдлэг, ур чадварын хувьд өндөр түвшинд байсан 11
Хүснэгт 17. Миний асуудлыг шийдвэрлэж өгөхөд тусалж чадах юм гэдэгт би итгэлтэй байсан
Хүснэгт 18. Өмгөөллийн үйл ажиллагаа, тактик нь оновчтой байсан. 11
Хүснэгт 19. Улсын өмгөөлөгчийн харилцаа, ёс зүй:
Хүснэгт 20. Миний асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй, шударга зарчмын дагуу ханддаг байсан.
Хүснэгт 21. Ажлын цаг, сахилга бат сайн байсан.
Хүснэгт 22. Үйлчилгээний орчин тав тухтай байсан
Хүснэгт 23. Бусад хүмүүст мэдэгдэхгүй байх орчин бүрдсэн байсан
Хүснэгт 24. Байгууллагын техник хэрэгсэл, унаа зэргээр хангалттай байсан
Хүснэгт 25. Хамаарлын судалгаа 14
Хүснэгт 26. Өмнөх онуудын харьцуулалт ба нэгдсэн үнэлгээ
Хүснэгт 27.Оролцогсдын хүйс
Хүснэгт 28.Оролцогсдын нас
Хүснэгт 29.Оролцогсдын боловсрол
Хүснэгт 30.Оролцогсдын ажил эрхлэлт
Хүснэгт 31 Оролцогсдын өрхийн орлого
Хүснэгт 32. Мэдээлэл олж авсан эрэмбэ
Хүснэгт 33. Хууль зүйн зөвлөгөө үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байсан
Хүснэгт 34. Надад хангалттай мэдээлэл өгдөг байсан
Хүснэгт 35. Мэдлэг, ур чадварын хувьд өндөр түвшинд байсан
Хүснэгт 36. Миний асуудлыг шийдвэрлэж өгөхөд тусалж чадах юм гэдэгт би итгэлтэй байсан
Хүснэгт 37. Харилцааны хувьд найрсаг байсан.
Хүснэгт 38. Техникийн хувьд асуудалгүй байсан
Хүснэгт 39. Сэтгэл ханамжийн хамаарал
Хүснэгт 40 Байгууллагын гадаад болон дотоод орчин

Хүснэгт 41. Дүүргүүдийг харьцуулах нь
Хүснэгт 42. Өмгөөллийн үйлчилгээ (2014-2020)
Хүснэгт 43. Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн орчин хангалттай бүрдсэн (улсын өмгөөлөгч)
Хүснэгт 44. Улсын өмгөөлөгчийн тоо ихсэж, иргэдэд үйлчлэх ачаалал буурсан
Хүснэгт 45. Ажлын ачаалалд тохирсон бүтэц, орон тоотой
Хүснэгт 46. Тогтвортой ажиллана гэсэн итгэл дүүрэн байна(улсын өмгөөлөгч
Хүснэгт 47. Тогтвортой ажиллана ба насны хамаарал (улсын өмгөөлөгч)
Хүснэгт 48. Би байгууллагынхаа үнэт зүйлс, нэр хүндийг
дээдлэн бахархан ажилладаг (Захиргааны ажилтан )
Хүснэгт49. Би байгууллагадаа цаашдаа ч тогтвортой ажиллана гэж боддог(Захиргааны ажилтан )
Хүснэгт 50. Төвийн бүтцийн матрицыг шалгасан нь
Хүснэгт 51. Байгууллагын ажлын гүйцэтгэлийг тооцох тогтолцоо сайжирсан (улсын өмгөөлөгч )
Хүснэгт 52. Чиг үүргийн давхардал байхгүй(захиргааны ажилтан)
Хүснэгт 53. Өмгөөлөгчийн хүйс
Хүснэгт 54. Өмгөөлөгчийн нас
Хүснэгт 55. Өмгөөлөгчийн ажилласан жил
Хүснэгт 56. Өмгөөлөгчийн оршин суугаа газар
Хүснэгт 57. Цалин хөлс урамшуулал
Хүснэгт 58. Ажлын орчин тав тух сайжирсан
Хүснэгт 59. Ажлаа хийхэд шаардагдах техник хэрэгсэл, унаа, томилолтын хангамж сайжирсан
Хүснэгт 60. Ажлын байрны стресс буурсан
Хүснэгт 61. Удирдлагын арга барил
Хүснэгт 62. Эерэг харилцаа, хандлага сайжирсан
Хүснэгт 63. Би цалиндаа сэтгэл хангалуун байдаг
Хүснэгт 64. Миний ажлын гүйцэтгэлийн үр дүнд тохирсон цалин урамшуулал өгдөг.
Хүснэгт 65. Бусад төрийн байгууллагатай харьцуулахад миний цалин боломжийн гэж боддог_ 47
Хүснэгт 66 . Өрөө тасалгааны тоо хүрэлцээтэй байдаг
Хүснэгт 67. Ажлаа хийж гүйцэтгэхэд хүрэлцэхүйц техник,
тоног төхөөрөмжөөр хангагдсан байдаг
Хүснэгт 68 . Ажлын өрөөнд дуу шуугиан багатай байдаг
Хүснэгт 69. Удирдлага, нэгжийн дарга нар чадварлаг тул би сэтгэл ханамжтай ажилладаг 49
Хүснэгт 70. Удирдлага, нэгжийн дарга нар миний ажлын гүйцэтгэлийг шударга дүгнэдэг
Хүснэгт 71. Удирдлага, нэгжийн дарга ёс зүй, зан харилцааны хувьд өндөр түвшинд байдаг
Хүснэгт 72. Миний сурч хөгжих, боломж, нийгмийн асуудлыг шийдэж өгдөг.

Хүснэгт 73. Хамт олондоо би сэтгэл хангалуун байдаг
Хүснэгт 74. Бид биенээ дэмжин ажилладаг
Хүснэгт 75. Маргаантай асуудлыг бид гомдол гаргах шатанд хүргэдэггүй 51
Хүснэгт 76 . Сургалтад тогтмол хамрагдснаар ур чадвар дээшилсэн

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн ажил эрхлэлт

Зураг 2. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн боловсролын түвшин

Зураг 3. Дүүргийн харьцуулалт

# УДИРТГАЛ

**Үнэлгээ хийх үндэслэл** Жил бүр төрийн байгууллагууд Засгийн Газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9.6, 9.7, 9.8, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны "Удирдамж, үзүүлэлт батлах тухай" 302 дугаар тушаалаар "Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж"-ын дагуу хэрэглэгчийн үнэлгээг хийдэг. Энэ ажлын хүрээнд ХЗДХЯ-ны харья Хууль зүйн туслалцааны төвийн хэрэглэгчийн 2020 оны үнэлгээг хийлээ. Төрийн байгууллагууд жил бүр хэрэглэгчийн үнэлгээг хийдэг ба энэ жилийн хувьд өмнөх 2016, 2017, 2018, 2019 оны тайлангуудад дүн шинжилгээ хийх замаар чанарын өөрчлөлт гарсан эсэхийг судлахыг зорьлоо.

Хууль зүйн туслалцааны төвийн эрх зүйн байдал нь Монгол улсын Үндсэн хуулиар суурь эх үндэс нь тодорхойлогддог.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар дугаар зүйлийн 14 дэх хэсэгт "Монгол Улсын иргэн нь "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... хууль зүйн туслалцаа авах ... эрхтэй" гэж, Тавин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Шүүгдэгчид ... хүсэлтээр нь буюу хуульд заасныаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ" гэж тус тус заасан байдаг. Мөн НҮБ-аас баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "... өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх" эрхтэй байхаар заасан(2018, 2019 оны тайланд мөн дурдагдсан). Шинэ Үндсэн хуулиас хойш төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажил нь Монголын өмгөөлөгчдийн холбоогоор дамжин Хууль зүй, дотоод хэргийн яамны удирдлага дор зохион байгуулагддаг байжээ. Өмгөөлөгч бүр төлбөрийн чадваргүй иргэнд жилд 2 удаа үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх үүргийнхээ дагуу туслалцаа үзүүлдэг байсан бөгөөд өмгөөлөгчид олгох урамшууллыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 69 дүгээр тушаалаар баталсан "Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний жишгийг тогтоох, зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан гаргах журам"-аар тогтоосон тарифаар олгож байв. 2006 онд Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг Засгийн газрын баталсан. Энэ хөтөлбөрийн хэрэгжүүлэх хүрээнд олон ажил хийгдсэн ба үр дүнд нь "Төлбөрийн чадваргүй

яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль"-ийг Улсын Их Хурлаас 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталж, 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Хууль зүйн туслалцааны төв байгууллагджээ.

Хууль зүйн туслалцааны төв (*цаашид Төв гэх*)нь одоогийн байдлаар 21 аймаг, Нийслэлийн 8 дүүрэг, хүн ам ихээр төвлөрсөн 2 суманд нийт 31 салбарт 72 албан хаагчтайгаар төлбөрийн чадваргүй яллагдагчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг гүйцэтгэж байна. Энэ Төвөөс үйлчилгээ авдаг иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг авах замаар цаашид байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн асуудлыг өмнө нь хийсэн 4 оны (2016, 2017, 2018, 2019) тайлан, энэ жилийн тайланг хамтатган дүн шинижлгээ хийж, зохих эрх бүхий байгууллагад санал, зөвлөмж хүргүүлэхийг зорьлоо.

**Үнэлгээний зорилго** Тус төвөөс төрийн үйлчилгээ авдаг иргэдээс сэтгэл ханамжийг түвшинг тогтоох, түүнчлэн иргэдэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, байгууллагын чиг үүрэг, хүний нөөцийн чадавхид шинжилгээг хийхэд чиглэгдэнэ.

**Үнэлгээ судалгааны төрөл:** Аливаа байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийхдээ 2 хэсэгт хуваана. Үүнд:

FROM OFFICE WORK- Тухайн байгууллагын хэрэглэгчид чиглэсэн үйлчилгээ, бүтээгдэхүүний үнэлгээ

BACK OFFICE WORK- Байгууллагын чиг үүрэгт хийсэн үнэлгээ: Дээр дурдсан Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу бол from office үнэлгээ хийнэ. Гэхдээ бид back office үнэлгээг ч судалгааны явцад давхар шинжлэх зорилго тавьсан.

**Үнэлгээ хийх арга зүй**

<u>Хэрэглэгчийн еренхий төлөв байдлыг тодорхойлоход хэрэглэх арга</u>

1. Үнэлгээний өгөгдөл цуглуулах арга:

Анхдагч эх сурвалж бол иргэдээс онлайн болон утсаар, биечлэн асуулга авах, ганцаарчилсан ярилцлага, ажиглалт

Хоёрдогч эх сурвалж бол байгууллагын баримт бичигт шинжилгээ хийнэ.

*Анхдагч эх сурвалж:*

- Санал асуулга авах эх олонлог, түүвэр бүрдүүлэлт

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ нийтлэг журам"-ын 9.7-д: "тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн насанд хүрсэн иргэдийн 5 хүртэлх хувийг хамруулна" гэж заасныг боломжит түүврийн хэмжээний дээд хязгаар гэж ойлгоно. Тухайн захиргааны байгууллагын төсвийн боломж, онцлог зэргээс

шалтгаалж түүврийн хэмжээг бууруулж болох боловч, статистикийн хувьд хүчинтэй түүврийн хэмжээнд байх ёстой[1]. Тухайн захиргааны байгууллагын төсвийн боломж, онцлог зэргээс шалтгаалж түүврийн хэмжээг бууруулж болно. (Хууль зүйн туслалцааны төвийнх нийт төсөв ойролцоогоор 1 тэрбум 300 сая төгрөг)

Төв нь Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай (*цаашид ТЧЯҮХЗТТХ гэх* )хуулийн хэрэгжилтийг холбогдох дээд байгууллага, удирдлагын өмнө хариуцан тайлагнаж, эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй яллагдагчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх, иргэдэд сургалт, сурталчилгаа хийх үйл үйл ажиллагааг зохистой удирдан зохион байгуулна гэсэн чиг үүргийн дагуу дараах байдлаар эх олонлогийг тооцов.

Жич: Хууль зүйн туслалцааны төвийн чиг үүрэг нь бусад захиргааны байгууллагаас ялгагдах онцлогтой. Төлбөрийн чадваргүй гэж өрхийн мэдээллийн санд бүртгэгдсэн болон өөрийгөө тодорхойлсон иргэдэд үйлчилдэг зорилтот хэрэглэгч дйилэнх эзэлнэ. Иймд эх олонлогийн томьёо бодохгүйгээр шууд түүврийн тоог гаргасан.

**Анхаар:** Энэ жил Ковид- 19 тэй холбоотойгоор гадуур шалгагдаж буй , мөн биечлэн зөвлөгөө авах иргэдээс санал авах боломжгүй, мөн хөдөө орон нутагт үнэлгээ хийх боломж гарсангүй.

Тусгай утсаар төлбөрийн чадваргүй гэхгүйгээр бүх иргэд хандах боломжтой байдаг тул тэднээс гаргасан жагсаалтын дагуу түүвэрлэн тоог авсан.

**Хүснэгт 1. Бүлэглэсэн түүвэр**

| Оролцогсод | Арга хэрэгсэл | Тоо |
|---|---|---|
| эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй яллагдагчид өмгөөллийн үйлчилгээ авсан хүн | ШШГЕГ-ын харья 461 | Эх олонлог 794: түүвэр-40 |
| Хууль зүйн зөвлөгөө авсан хүн | Ковид-19 тэй холбоотой хөл хорионд байсан тул утсаар үйлчилгээ авсан хүмүүсээс асуумж бөглүүлэх | Эх олонлог 1093: Түүвэр 40 |
| Хорооны нийгмийн ажилтан | Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул | Түүвэр 10 |
| **Нийт** | | **90** |

[1] ЗГХЭГ-ын удирдамж

**Хүснэгт 2. Ажилтны сэтгэл ханамжийн түвэр**

| Иргэдийн төрөл | Арга хэрэгсэл | Тоо |
|---|---|---|
| Улсын өмгөөлөгч | Онлайн санал асуулга | Эх олонлог 55: бүгд оролцох |
| Захиргааны ажилтан | Санал асуулга бичгээр өгөх | Эх олонлог 10: бүгд оролцох |
| Нийслэлийн хороодын нийгмийн ажилтан | Утсаар санал авах | 10 |
| **Нийт** | | **75** |

- Ярилцлагын арга

Улс оронд бий болсон нөхцөл байдлаас шалтгаалан онлайн, цахим хэлбэрээр ярилцлагын асуултыг илгээн үнэлгээг авсан болно. Нийт 10 хүнээс авсан.

- Ажиглалтын арга

Хууль зүйн туслалцааны төвийн захиргаа байрладаг газар, Хан-Уул дүүргийн үйлчилгээ үзүүлдэг газарт ажиглалт хийлээ. Ковид-19 –өөс шалтгаалан орон нутагт судалгаа хийж чадсангүй.

*Хоёрдогч эх сурвалж:*

Баримт бичгийн судалгаа байна.

**Хүснэгт 3. Хэрэглэгчийн үнэлгээг хийх шалгуур үзүүлэлт нь**

| | |
|---|---|
| Үйлчилгээний чанар | Харилцааны соёл, ёс зүй |
| Үйлчилгээний хүртээмж | Үйлчилгээний орчин |

Судалгааны өгөгдөл шинжлэх арга

Нэг хувьсагчийн тархалтын шинжилгээг SPSS 23 программыг ашиглан боловсруулалт хийлээ.

# НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

## 1.1 Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөл үзүүлэх үйлчилгээнд хийсэн шинжилгээ

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуульд зааснаар тус Төв нь төлбөрийн чадваргүй яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор улсын өмгөөлөгчөөс үзүүлж байгаа хууль зүйн зөвлөгөө болон өмгөөллийн үйлчилгээг улсын өмгөөлөгч нар үзүүлдэг байна. Эдгээр хүмүүст хүснэгт 3-т заасан үйлчилгээний чанар, хүртээмж, улсын өмгөөлөгчийн харилцаа, ёс зүй, үйлчилгээний орчин гэсэн 4 шалгуур үзүүлэлтээр сэтгэл ханамжийн түвшинг гаргасан.

**Судалгаа авахад гарсан бэрхшээл**: Ковид-19-ийн хөл хорионд 461 рүү орох, мөн гадуур шалгагдаж буй хүмүүстэй биечлэн уулзах боломжгүй нөхцөл байдал үүссэн. Тиймээс ШШГЕГ-т бичгээр хүсэлт гарган, улмаар санал асуулгын анкет 40 илгээснээс 20-ийг бөглөж ирсэн болно.

Санал асуулга:

А.Оролцогсдын ерөнхий мэдээлэл:

Нийт 20 хүний ерөнхий мэдээллийг хүйс, нас, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлого гэсэн хэмжээс тавьж асуусан. SPSS-ын програмд оруулсан үр дүнгээ хүснэгтээр үзүүлж байна.

Хүйсийн хувьд нийт 20 хүнээс 19 хүн нь эрэгтэй, 1 эмэгтэй байв.

**Хүснэгт 4. Оролцогсдын нас**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | 19-30 | 14 | 70.0 | 70.0 | 70.0 |
| | 31-45 | 4 | 20.0 | 20.0 | 90.0 |
| | 46-59 | 2 | 10.0 | 10.0 | 100.0 |
| | Total | 20 | 100.0 | 100.0 | |

Насыг 18-аас доош, 19-30, 31-45, 46-59, 60-ээс дээш насны гэж 5 бүлэгт хуваасан. 18-аас доош болон 60-ээс дээш оролцогч байсангүй.

**Хүснэгт 5. Боловсрол**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Дээд | 4 | 20.0 | 20.0 | 20.0 |
| | Тусгай дунд | 4 | 20.0 | 20.0 | 40.0 |
| | Бүрэн дунд | 11 | 55.0 | 55.0 | 95.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бүрэн бус | 1 | 5.0 | 5.0 | 100.0 |
| Total | 20 | 100.0 | 100.0 | |

Боловсролын хувьд дээд, тусгай дунд, бүрэн дунд, бүрэн бус, бага буюу бичиг үсэггүй гэсэн 5 бүлэгт хуваасан. Харин энэ удаагийн оролцогсдын дунд бага ба бичиг үсэггүй хүн байсангүй.

**Хүснэгт 6. Ажил эрхлэлтийн байдал**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | хувиараа | 9 | 45.0 | 45.0 | 45.0 |
| | тэтгэвэр, халамж | 1 | 5.0 | 5.0 | 50.0 |
| | компани, аж ахуйн нэгж | 2 | 10.0 | 10.0 | 60.0 |
| | ажилгүй | 8 | 40.0 | 40.0 | 100.0 |
| | Total | 20 | 100.0 | 100.0 | |

Ажил эрхлэлтийн байдлыг тандахын тулд нээлттэй асуулт тавьсан. Нээлттэй асуултад: мужаан бригад, мужаан, дасгалжуулагч, компанид инженер механик, сүлжээний худалдагч, хөдлөх зууч, групт, хувиар ажил эрхэлдэг гэж нэрлэж хариулсан. Энэ хүмүүсийн өрхийн орлогоо хэрхэн тодорхойлсныг үргэлжлүүлэн тандсан.

**Хүснэгт 7. Ажил эрхлэлтийн байдал * өрхийн орлого**

| | | өрхийн орлого | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 0-500000 | 500001-1000000 | 1000000-аас дээш | Total |
| таны ажил эрхлэлтийн байдал | хувиараа | 5 | 3 | 1 | 9 |
| | тэтгэвэр, халамж | 0 | 1 | 0 | 1 |
| | компани, аж ахуйн нэгж | 2 | 0 | 0 | 2 |
| | ажилгүй | 4 | 3 | 1 | 8 |
| Total | | 11 | 7 | 2 | 20 |

Судалгаанд оролцогсдын хариултаас харахад хувиараа, компани аж ахуйн нэгжид ажилладаг мөртлөө 500000 –төгрөгөөс доош өрхийн орлоготой гэж бичсэн бол 500000 төгрөөс дээш гэж орлоготой ч ажилгүй гэж 4 хүн хариулсан байна.

Төлбөрийн чадваргүй хүмүүсийн хувьд ажил эрхлэлт, өрхийн орлого гэж асуулт тавьсны зорилго нь ТЧЯҮХЗТТХ-ийн 7.1.1.Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн

гишүүн, 7.1.2.энэ хуулийн 7.1.1-д заасан нэгдсэн санд бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болохоо тодорхойлсон хүнийг тодорхойлсон хуулийн заалтуудын хэрэгжилтийг тандахад чиглэгдэнэ.

Ажил эрхлэлтийг боловсролтой нь харьцуулж шинжлэв.

**Хүснэгт 8. Ажил эрхлэлтийн байдал ба боловсрол**

| | | Боловсрол | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | дээд | Тусгай дунд | Бүрэн дунд | Бүрэн бус | Total |
| таны ажил эрхлэлтийн байдал | хувиараа | 2 | 3 | 4 | 0 | 9 |
| | тэтгэвэр, халамж | 0 | 0 | 1 | 0 | 1 |
| | компани, аж ахуйн нэгж | 2 | 0 | 0 | 0 | 2 |
| | ажилгүй | 0 | 1 | 6 | 1 | 8 |
| Total | | 4 | 4 | 11 | 1 | 20 |

Төлбөрийн чадваргүй яллагдагчийн дийлэнх нь бүрэн дунд, ажилгүй хүмүүс байна. Энэ хэсэгт бичиг үсэггүй, орлогогүй хүмүүсийн хувийг тандах зорилго агуулсан боловч судалгааны тооцоолоогүй нөхцөл байдлаас үүдэн сонгогдсон хорин хүн дотор байсангүй. Гэхдээ Төвийн улсын өмгөөлөгчийн туслах, захиргааны ажилтантай энэ талаар ярилцлага хийж тодруулга авсан.

*Шигтгээ*

*Манай улсын өмгөөлөгчийн үйлчилгээ авдаг хүмүүсийн дунд бичиг үсэг мэдэхгүй, орлогогүй хүмүүс байдаг. Тэр хүмүүсээс үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгааг биечлэн авахаас өөр аргагүй. Ялангуяа ийм хүмүүс асуултад хариулт өгөхдөө эмээсэн, заримдаа худлаа хариулт өгөх явдал өмнөх судалгаанаас харагдаж байсан.*

Б. Оролцогсдын зан төлөвийн байдлыг тодорхойлох судалгаа

Судалгаанд оролцогсдоос төлбөрийн чадвараа хэрхэн тодорхойлсныг тодруулах зорилгоор дараах хоёр асуулт тавьсан.

*1.Та өрхийн мэдээллийн санд төлбөрийн чадваргүй иргэн гэж бүртгэгдсэн үү ?*

*2.Та өрхийн мэдээллийн санд бүртгүүлээгүй ч өөрийгөө төлбөрийн чадваргүй гэж тодорхойлсон уу?*

Судалгаанд оролцогсдоос эхний асуултанд нийт 20 хүнээс тийм гэж 1 хүн хариулсан. Энэ хүн хувиараа ажил эрхэлдэг, өрхийн орлого, 500000 төгрөг гэж нэрлэж бичсэн, эрэгтэй, 19-30 насны ангилалд хамаарч байв. Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу 409 онооноос доош байх

ёстой. Асуултын хариултыг ярилцлагын аргаар шалгаж болох байсан ч харамсалтай энэ удаа боломжгүй байлаа.

Хоёрдах асуултад нийт 19 хүн хариулт өгсөн байна.

**Хүснэгт 9. Төлбөрийн чадваргүй гэж өөрийгөө тодорхойлсон**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | тийм | 14 | 70.0 | 73.7 | 73.7 |
| | үгүй | 3 | 15.0 | 15.8 | 89.5 |
| | мэдэхгүй | 2 | 10.0 | 10.5 | 100.0 |
| | Total | 19 | 95.0 | 100.0 | |
| Missing | System | 1 | 5.0 | | |
| Total | | 20 | 100.0 | | |

Төлбөрийн чадваргүй гэж өөрөө тодорхойлсон хүмүүсээс өрхийн орлогын талаар тодруулга авсан.

**Хүснэгт 10. Төлбөрийн чадваргүй гэж өөрийгөө тодорхойлсон ба өрхийн хамаарал**

| | | өрхийн орлого | | | Total |
|---|---|---|---|---|---|
| | | 0-500000 | 500001-1000000 | 1000000-аас дээш | |
| төлбөрийн чадваргүй гэж өөрийгөө тодорхойлсон уу | тийм | 8 | 4 | 2 | 14 |
| | үгүй | 2 | 1 | 0 | 3 |
| | мэдэхгүй | 1 | 1 | 0 | 2 |
| Total | | 11 | 6 | 2 | 19 |

Төлбөрийн чадваргүй гэж өөрийгөө тодорхойлсон атал орлого нь дээр дурдсан онооноос өндөр байгаа 6 хүн судалгаанд оролцсон байна. Мөн 500000 төгрөгөөс дээш өрхийн орлоготой үйлчилгээ авсан хүмүүсээс үгүй гэж 1, мэдэхгүй гэж 1 гэж тус бүр хоёр хүн хариулжээ. Нийт 8 хүний асуудал эргэлзээ төрүүлсэн учраас дахин санал асуулга авч өгсөн ШШГЕГ-аас тодруулга авсан.

*Шигтгээ*

461 дүгээр ангид өмгөөлөгч авч чадахгүй байгаа хүмүүст бид улсын өмгөөлөгчийг зааж өгдөг юм. Энэ судалгаанд оролцсон бүх хүмүүс улсын өмгөөлөгч авсан.

Өрхийн мэдээллийн санд бүртгүүлээгүй ч өөрийгөө төлбөрийн чадваргүй гэдгээ тодорхойлсныг улсын өмгөөлөгч хэрхэн таньдаг вэ? гэдгийг тодруулав.

*Шигтгээ*

*Мэдээж нэгд 409 онооноос доош байна. Хоёрдугаарт судалгаанд хамрагдаагүй гэсэн хүмүүс орж ирдэг. Манай хуулийн 7.5.Улсын өмгөөлөгч хууль зүйн туслалцаа*

*үзүүлэх явцад үйлчлүүлэгчийн төлбөрийн чадваргүй эсэхэд эргэлзээ төрвөл төлбөрийн чадваргүй болохоо тодорхойлсон өргөдөлд заасан нөхцөлийг шалгаж, төлбөрийн чадвартай болох нь тогтоогдвол хууль зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах шийдвэрийг бичгээр гаргаж, хувийг үйлчлүүлэгчид өгнө гэж заасны дагуу шалгадаг.*

*Гэхдээ энэ талын нарийвчилсан зохицуулалт өнөөдөр зайлшгүй хэрэгтэй байна. Бид ч өөрсдөө ачаалал нэмээд хүн өмгөөлөөд явахыг бодохгүй шүү дээ.*

*Ярилцлагаас*

Энэ судалгаанд хамрагдаагүй гэж цагдан хорихоос санал болгодог зохицуулалтыг эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай.

*Та улсын өмгөөлөгчийн талаарх мэдээллийг анх хаанаас авсан бэ?* гэсэн асуултад оролцогсдоос дараах хэмжээсээр асуув.

1. www. lac.gov.mn 2. Тусгай дугаар 7000-1982, 3. Найз нөхдөөсөө 4. Хэвлэл мэдээллийн хэрэгслээс. 5. Гэр бүлийн орчин 6. Хороо, багийн захиргааны ажилтнуудаас , 7. Цагдаагийн байгууллагаас 8. Өмгөөллийн товчоод 9. Хуульчдын холбоо болон Хууль зүйн Үндэсний хүрээлэн, 10. Шүүхээс 11. Бусад

**Хүснэгт 11. Мэдээллийг хаанаас авсан бэ?**

| | | B1 | B2 | B3 | B4 | B5 | B6 | B7 | B8 | B9 | B10 | B11 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| N | Valid | **1** | **0** | **6** | **1** | **2** | **5** | **2** | **2** | **0** | **1** | **6** |
| | Missing | 19 | 20 | 14 | 19 | 18 | 15 | 18 | 18 | 20 | 19 | 14 |

Бусад гэсэн нээлттэй асуултад шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, цагдан хорихоос гэжээ.

Мөн энэ талаар Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн хорооны нийгмийн ажилтан болон Хан-Уул дүүргийн 17 дугаар хорооны 10 иргэнээс асуумж авсан.

Эдгээр 10 иргэн орон сууцны барилгын жижүүр, үйлчлэгч, барилга байгууламжийн хашааны газрын манаачаар ажилладаг. Тэд хөдөө орон нутгаас шилжин ирсэн түр бүртгэлтэй суудаг, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалинждаг, зарим иргэд хорогдох оронтой гээд хөлс авдаггүй амьдардаг байна.

Нийт 10 иргэнээс Хууль зүйн зөвлөгөөг хэрэг болоход хаанаас авдаг гэж асуухад: Хорооноосоо очиж асуусан гэж бүгд хариулсан. Хорооны ажилтнаас тодруулахад тэд бид төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн туслалцаа авах талаар орж ирэхэд улсын өмгөөлөгч нарын хаяг, утсыг хэлж өгдөг гэжээ. Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн хороодод улсын өмгөөлөгчийн талаар мэдээлэл байна.

Мэдээллийг цагдан хорих газар, найз нөхөд, гэр бүлээсээ орчноос голчлон авч байна.

**Хүснэгт 12. Өмнөх онуудын харьцуулалт**

| Он | Мэдээлэл авсан эх сурвалж (хамгийн их авсан ) |
|---|---|
| 2018 | Танил тал, хүмүүсийн ам дамжсан ярианаас |
| 2019 | Нийгмийн сүлжээ, лавлахаас |

В. Улсын өмгөөлөгчөөс үзүүлсэн сэтгэл ханамжийн судалгаа

Сэтгэл ханамжийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг үнэлгээний арга зүйн хэсгээс харна уу.

Үйлчилгээний хүртээмж:

**Хүснэгт 13. Өмгөөллийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байсан**

| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
|---|---|---|---|---|
| Count | Count | Count | Count | Count |
| 16 | 1 | 2 | 1 | 0 |

Хэдийгээр огт санал нийлэхгүй гэсэн хариулт өндөр байгаа ч түүврийн хэмжээ бага, хамтдаа судалгаа аваагүй зэрэг үнэлгээний найдвартай байдалд алдаа гарч болзошгүй гэж үнэлэгээний баг үзэж байна. Үүнийг улсын өмгөөлөгчийн сэтгэл ханамжийн үзүүлэлттэй хамаарлыг олох замаар үнэлэх нь оновчтой.

**Хүснэгт 14. 3-аас дээш удаа надтай уулзаж зөвлөгөө өгдөг байсан**

| 3-аас дээш удаа надтай уулзаж зөвлөгөө өгдөг байсан | | | | |
|---|---|---|---|---|
| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
| Count | Count | Count | Count | Count |
| 11 | 6 | 2 | 1 | 0 |

3 –аас гэж давтамжийг заасан нь тухайн үйлчилгээний хүртээмжийг шалгах үзүүлэлт байдаг. Энэ хариултыг улсын өмгөөлөгчийн иргэдэд үзүүлсэн сар, жилийн хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээнүүдийн дундаж тоотой харьцуулах ёстой. Хэрэв нэг өмгөөлөгчид ногдох ачаалал өндөр байвал дээрх 3 удаа гэсэн давтамж буурна. Тиймээс энэ хүчин зүйлийг үйлчилгээний хүртээмжийг тооцоход харгалздаг.

**Хүснэгт 15. Надад хангалттай мэдээлэл өгдөг байсан**

| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
|---|---|---|---|---|
| Count | Count | Count | Count | Count |
| 14 | 2 | 3 | 1 | 0 |

Энэ асуултын зорилго улсын өмгөөлөгч тухайн үйлчлүүлэгчид холбогдсон хэргийн талаарх хууль зүйн үндэслэл, бусад мэдээллийг хангалттай түвшинд өгсөн эсэхийг тандах зорилготой.

Үйлчилгээний чанар:

**Хүснэгт 16. Мэдлэг, ур чадварын хувьд өндөр түвшинд байсан**

| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
|---|---|---|---|---|
| Count | Count | Count | Count | Count |
| 8 | 7 | 5 | 0 | 0 |

Энэ хариултыг мөн ярилцлагын аргаар шалгах ёстой. Мөн улсын өмгөөлөгчийн жилд хамрагдсан сургалт, хөгжлийн тоотой харьцуулж үнэлэх нь зүйтэй юм. Тайлангийн хоёрдугаар бүлгийн 2.1 улсын өмгөөлөгчийн сэтгэл ханамжийн хэсгээс сургалт, хөгжлийн тоог харах боломжтой.

**Хүснэгт 17. Миний асуудлыг шийдвэрлэж өгөхөд тусалж чадах юм гэдэгт би итгэлтэй байсан**

| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
|---|---|---|---|---|
| Count | Count | Count | Count | Count |
| 10 | 4 | 4 | 2 | 0 |

Энэ үнэлгээнд хамрагдсан хүмүүсийн хувьд биечлэн судалгаа аваагүй учраас улсын өмгөөлөгч хэдэн удаа уулзсан, ямар арга хэмжээг авч байсан талаарх мэдээллээр шалгах ёстой юм.

**Хүснэгт 18. Өмгөөллийн үйл ажиллагаа, тактик нь оновчтой байсан.**

| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
|---|---|---|---|---|
| Count | Count | Count | Count | Count |
| 9 | 7 | 2 | 2 | 0 |

Дээрх тайлбаруудтай ижил.

Улсын өмгөөлөгчийн харилцаа, ёс зүй:

**Хүснэгт 19. Улсын өмгөөлөгчийн харилцаа, ёс зүй:**

| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
|---|---|---|---|---|
| Count | Count | Count | Count | Count |
| 8 | 5 | 5 | 2 | 0 |

**Хүснэгт 20. Миний асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй, шударга зарчмын дагуу ханддаг байсан.**

| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
|---|---|---|---|---|
| Count | Count | Count | Count | Count |
| 11 | 4 | 4 | 1 | 0 |

**Хүснэгт 21. Ажлын цаг, сахилга бат сайн байсан.**

| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
|---|---|---|---|---|
| Count | Count | Count | Count | Count |
| 8 | 5 | 6 | 1 | 0 |

Дээрх хариултуудын хувьд улсын өмгөөлөгчийн иргэдэд үзүүлсэн сар, жилийн хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээнүүдийн дундаж тоотой харьцуулах, сургалт хөгжлийн тоо, давтамжийг харьцуулж гаргана.

Үйлчилгээний орчин:

**Хүснэгт 22. Үйлчилгээний орчин тав тухтай байсан**

| Үйлчилгээний орчин тав тухтай байсан |
|---|

| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
|---|---|---|---|---|
| Count | Count | Count | Count | Count |
| 10 | 4 | 4 | 2 | 0 |

461 дүгээр анги болон Төвийн үйлчилгээ үзүүлдэг газар бол стандартын шаардлага хангахгүй байгаа талаар өмнөх 2018, 2019 оны тайлангууд дурдагдсан байна.

Шинэ байрлалд очсон Төвийн байр нь үйлчлүүлэгчийн эрхийг хангах зорилгоор олон улсын болон дотоодын стандартад нийцсэн өрөөг тохижуулж байна.Энэ өрөө нь дуу намсгагчтай, үйлчлүүлэгч өөрийн асуудлаа ярих боломжтой стандартын сандал, өрөөг нь сэтгэл тайвшруулах өнгөөр будаж янзалжээ. Ирэх 2021 онд энэ төвд байрлаж буй дүүргийн үйлчлүүлэгч хууль зүйн зөвлөгөө авах орчин сайн болох төлөвтэй байна.

**Хүснэгт 23. Бусад хүмүүст мэдэгдэхгүй байх орчин бүрдсэн байсан**

| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
|---|---|---|---|---|
| Count | Count | Count | Count | Count |
| 8 | 4 | 5 | 2 | 1 |

Өмнөх жилүүдийн хэрэглэгчийн үнэлгээний тайланд бас дурдагдаж байсан улсын өмгөөлөгчийн байрны хүртээмжээс болж үйлчлүүлж буй хүмүүсийн сэтгэл ханамжид хүчтэй нөлөөлөл үзүүлдэг байна. Орон нутгийн хувьд нэг цэгийн үйлчилгээний хэсэгт байрлах тул олон иргэдийн дунд асуудлаа ярина гэдэг үйлчлүүлэгчийн хувьд маш хэцүү байдаг. Энэ асуудал энэ 2020 онд давтагдсаар байна.

**Хүснэгт 24. Байгууллагын техник хэрэгсэл, унаа зэргээр хангалттай байсан**

| Огт санал нийлэхгүй байна. | Санал бараг нийлэхгүй байна | Дунд зэрэг | Ерөнхийдөө санал нийлж байна | Бүрэн санал нийлж байна. |
|---|---|---|---|---|
| Count | Count | Count | Count | Count |
| 8 | 5 | 6 | 0 | 1 |

Энэ асуултын зорилго улсын өмгөөлөгчид үйлчлүүлэгчид туслалцаа үзүүлэх бичиг цаасны хэрэглээ, компьютер зэргийг асуусан. Харин оролцогсод хэр зэрэг

зөв ойлгосон эсэх нь эргэлзээтэй байх магадлалтай. Мөн улсын өмгөөлөгчийн хувьд ажлын онцлогоос болж байнга нэг газраас нөгөө газарт очих хэрэгцээ шаардлагатай тул унааны хангамж, хүрэлцээ муу байдаг.

**Нэгдсэн үнэлгээ:**

Өмнөх 4 тайланд дурдагдсан асуудлууд дээр үндэслэж, чанарын өөрчлөлт хэр байхыг харьцуулах замаар асуулт бэлдсэн. Асуултын найдвартай байдал буюу альфа-гийн хэмжээ 0,7 –ээс дээш байсан. 4 шалгуур үзүүлэлт 12 хэмжээсээр сэтгэл ханамжийн ерөнхий түвшинг гаргахыг зорьсон. Иймд тухайн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа тул тэд ямар хэрэгт, хэдэн удаа холбогдсон зэрэг мэдээллийг аваагүй болно.

Нэгдсэн үнэлгээг гаргахдаа шалгуур тус бүрийн 3 дэд асуултуудын дунджийг олохын тулд 4 шинэ хувьсагч үүсгэлээ.

**Хүснэгт 25. Хамаарлын судалгаа**

| Хамаарлын судалгаа | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Model | | Unstandardized Coefficients | | Standardized Coefficients | t | Sig. |
| | | B | Std. Error | Beta | | |
| 1 | (Constant) | .603 | .567 | | 1.062 | .309 |
| | access | .571 | .263 | .555 | 2.170 | .051 |
| | quality | .255 | .542 | .217 | .470 | .647 |
| | ethics | -.051 | .591 | -.044 | -.086 | .933 |
| | framework | .063 | .231 | .074 | .272 | .790 |

a. Dependent Variable: Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж ямар байна вэ?

4 хувьсагчийн хувьд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг энгийн шугаман корелляциар гаргасан болно. Үйлчилгээний хүртээмжийн хувьд бусад гурван хувьсагчаас илүү хамааралтай буюу сэтгэл ханамжгүй байгаа нь өмгөөлөгчийн ачаалалаас шалтгаалж байна гэж үзэж болно. Харин өмгөөлөгчийн зан харилцаа, ёс зүйн хувьд хамгийн бага утга авсан сэтгэл ханамжийн хувьд бусад гурван хувьсагчаасаа илүү сэтгэл ханамжтай байна гэж дүгнэж байна.

**Хүснэгт 26. Өмнөх онуудын харьцуулалт ба үнэлгэ**

| № | Он | Хамрагдсан хүний тоо | Үнэлгээ |
|---|---|---|---|
| 1 | 2016 | 461-т байгаа хүмүүсийн тоог ялгаж гараагүй байна. | Тусгайлсан үнэлгээ байхгүй. Хууль зүйн зөвлөгөө ба өмгөөллийн үйлчилгээг нэгтгэсэн дүн 89,1 % |
| 2 | 2017 | 47 хүн | Тусгайлсан үнэлгээ байхгүй Нийт үнэлгээ 88% |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | 2018 | Нийт 120 хүнээс 461-ээс хэд авсан тодорхойгүй | Тусгайлсан үнэлгээ байхгүй Нийт үнэлгээ 77,7 |
| 4 | 2019 | 92 хүн | Үнэлгээ 91,2 % |
| 5 | 2020 | 20 хүн | Түүврийн хэмжээ бага тул шууд үнэлгээ хийх боломжгүй байна. Хамаарлын коэф-тоос харахад **70 %** гарч байна. |

## 1.2. Тусгай утсаар хууль зүйн зөвлөгөө авсан иргэдийн сэтгэл ханамжид хийсэн судалгаа

2018 онд Засгийн газраас баталсан " Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэгч байгуулагч болох ХЗДХЯ өөрийн харьяа байгууллагууд болох Хууль зүйн Үндэсний Хүрээлэн, Хууль зүйн туслалцааны төвд иргэдэд утсаар үнэ төлбөргүй зөвлөгөөг өгөх ажлыг даалгасан байна.

Төвөөс хууль зүйн лавлах тусгаар дугаар бүхий 7000-1982 юм.

2020 оны байдлаар 3 улирлын байдлаар хууль зүйн зөвлөгөө авсан утасны жагсаалтанд байх 1039 хүнээс түүврийн аргаар 40 хүн төлөвлөсөн боловч иргэд утсаар судалгаа өгөх дургүй байв. Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан иргэдийн дунд уурлах, доромжлох зэргээр судалгаа хийхэд хүндрэл учруулж байсан. Энэ талаар Төвд мэдэгдсэн болно.

**Санал:** Төвөөс энэ утсанд сэтгэл ханамжийн судалгааг автоматаар санал өгдөг тохиргоотой байлгах зохимжтой болов уу.

Нийт 20 хүнээс хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хүчинтэй гэж тооцлоо.

А.Оролцогсдын ерөнхий мэдээлэл

**Хүснэгт 27.Оролцогсдын хүйс**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Эрэгтэй, | 4 | 20.0 | 20.0 | 20.0 |
| | Эмэгтэй. | 16 | 80.0 | 80.0 | 100.0 |
| | Total | 20 | 100.0 | 100.0 | |

Санамсаргүй түүврээс сонгогдсон иргэдээс хүйсийн хувьд эмэгтэйчүүд энэ утсанд хандсан байна. Эмэгтэйчүүд гэр бүл, гэр бүлийн хүчирхийлэл, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хандсан байна.

**Хүснэгт 28.Оролцогсдын нас**

| Таны нас | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
| Valid | 19-25 | 6 | 30.0 | 30.0 | 30.0 |
| | 26-45 | 6 | 30.0 | 30.0 | 60.0 |
| | 46-59 | 4 | 20.0 | 20.0 | 80.0 |
| | 60-ээс дээш | 4 | 20.0 | 20.0 | 100.0 |
| | Total | 20 | 100.0 | 100.0 | |

Насны хувьд 18 –аас доош гэсэн ангилал оруулсан боловч санамсаргүй түүврийн аргаар сонгосон иргэд дунд байсангүй. Иймд 18-45 насны залуу, идэр насныхан хууль зүйн зөвлөгөө авчээ.

**Хүснэгт 29.Оролцогсдын боловсрол**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | дээд | 10 | 50.0 | 50.0 | 50.0 |
| | бүрэн дунд | 7 | 35.0 | 35.0 | 85.0 |
| | бүрэн бус | 3 | 15.0 | 15.0 | 100.0 |
| | Total | 20 | 100.0 | 100.0 | |

Бага боловсролтой, бичиг үсэг тайлагдаагүй иргэд сонгогдсон түүвэр дотор байсангүй.

**Хүснэгт 30.Оролцогсдын ажил эрхлэлт**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | хувиараа | 6 | 30.0 | 30.0 | 30.0 |
| | тэтгэвэр, халамж | 6 | 30.0 | 30.0 | 60.0 |
| | ажилгүй | 8 | 40.0 | 40.0 | 100.0 |
| | Total | 20 | 100.0 | 100.0 | |

Энэ хэсэгт төрийн байгууллага, компани, аж ахуйн нэгжид ажилладаг хүн байсангүй.

**Хүснэгт 31.Оролцогсдын өрхийн орлого**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | 0-500000 | 12 | 60.0 | 60.0 | 60.0 |
| | 500001-1000000 | 3 | 15.0 | 15.0 | 75.0 |
| | 1000000-ээс дээш | 5 | 25.0 | 25.0 | 100.0 |
| | Total | 20 | 100.0 | 100.0 | |

Өрхийн орлогын талаар мэдээлэл хэлэхдээ их цааргалж байсан ба ерөнхий дундаж тоог хэлж байв. Мөн эдгээр хүмүүсээс эрх бүхий байгууллагаас тогтоосон ядуурлын шугамаар доогуур өрхийн гишүүн мөн эсэхийг гэж тодруулахад 20 оролцогч бүгд “биш” гэж хариулж байсан. Харин өрхийн орлогын хэмжээг харахад нийт 20 оролцогчоос 60 хувьд бага орлоготой өрхөд хамаарах үзүүлэлттэй байна.

Б. Оролцогсдын зан төлөвийн байдлыг тодорхойлох судалгаа

*Та Тусгай дугаар 7000-1982 -ыг анх хаанаас мэдсэн бэ?* гэж нээлттэй асуулт тавьсан.

**Хүснэгт 32. Мэдээлэл олж авсан эрэмбэ**

**Мэдээлэл олж авсан эрэмбэ**

| | | Responses | | Percent of Cases |
|---|---|---|---|---|
| | | N | Percent | |
| call[a] | Фэйсбүүк | 3 | 15.8% | 15.8% |
| | Интернэт | 6 | 31.6% | 31.6% |
| | Телевиз | 5 | 26.3% | 26.3% |
| | Найз нөхдөөсөө | 1 | 5.3% | 5.3% |
| | Төрийн байгууллага буюу ХЗТТ ба Хуульчдын холбоо, Хүний эрхийн комисс | 3 | 15.8% | 15.8% |
| | Өмгөөлөгч нараас | 1 | 5.3% | 5.3% |
| Total | | 19 | 100.0% | 100.0% |

a. Dichotomy group tabulated at value 1.

Нийт 20 хүнээс нээлттэй асуулт тавьсан юм. Тэд нээлттэй асуултад дээрх хүснэгтэд заасан хариултыг өгсөн. Нэг хүний хариулт найз нөхдөөсөө болон фэйсбүүкээс харсан гэж хоёр хариултыг сонгосон байв. Мөн интернэт гэж хариулсан хүмүүс мэдээллийн сайт, зар сурталчилгаанаас мэдсэн гэж хариуллаа.

В. Улсын өмгөөлөгчөөс утсаар хууль зүйн зөвлөгөө үзүүлсэн сэтгэл ханамжийн судалгаа

Үйлчилгээний хүртээмж:

**Хүснэгт 33. Хууль зүйн зөвлөгөө үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж байсан**

| Дундаж | | санал нийлэхгүй байна | дунд зэрэг | бүрэн санал хийлж байна | Total |
|---|---|---|---|---|---|
| access | 1.00 | 3 | 0 | 0 | 3 |
| | 1.50 | 0 | 1 | 0 | 1 |
| | 2.00 | 0 | 9 | 0 | 9 |
| | 2.50 | 0 | 1 | 0 | 1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 3.00 | 0 | 0 | 6 | 6 |
| Total | | 3 | 11 | 6 | 20 |

Энэ судалгаанд оролцогсдын хувьд өмнөх төлбөрийн чадваргүй гэж өмгөөлөл авсан иргэдээс сэтгэл ханамжийн ерөнхий түвшин өндөр байв. Гурван хэмжээс авсан үндэслэл утсаар авч байгаатай холбоотой юм. Түргэн шуурхай өгөөгүй гэж хариулсан 3 хүнээс илүү тодруулж асуухад тухайн үед асуудлыг минь бүрэн сонсоогүй гэж нэг, утсаа аваагүй гэж хоёр хүн хариулсан.

**Хүснэгт 10. Надад хангалттай мэдээлэл өгдөг байсан**

| | | санал нийлэхгүй байна | дунд зэрэг | бүрэн санал хийлж байна | Total |
|---|---|---|---|---|---|
| access | 1.00 | 3 | 0 | 0 | 3 |
| | 1.50 | 1 | 0 | 0 | 1 |
| | 2.00 | 0 | 9 | 0 | 9 |
| | 2.50 | 0 | 0 | 1 | 1 |
| | 3.00 | 0 | 0 | 6 | 6 |
| Total | | 4 | 9 | 7 | 20 |

Энэ үзүүлэлтэд санал нийлэхгүй гэж хариулт өгсөн хүмүүсээс өнгөц, зөвхөн чиглүүлээд орхисон гэсэн шүүмжилж байв. Харин иргэд энэ утасны үндсэн зорилгыг сайн ойлгоогүйгээс үргэлжлүүлэн өмгөөлөгч авах ёстой талаар нэгдсэн ойлголтгүй байлаа. Мөн улсын өмгөөлөгчийн ажилласан, мэргэшсэн байдлаас харахад эрүүгийн чиглэлээр дагнадаг тул бусад салбар эрх зүйн талаар утсаар шууд хариулт өгөх боломжгүй байдаг.

Үйлчилгээний чанар:

**Хүснэгт 35. Мэдлэг, ур чадварын хувьд өндөр түвшинд байсан**

| | | санал нийлэхгүй байна | дунд зэрэг | бүрэн санал хийлж байна | Total |
|---|---|---|---|---|---|
| quality | 1.00 | 3 | 0 | 0 | 3 |
| | 1.50 | 1 | 1 | 0 | 2 |
| | 2.00 | 0 | 8 | 0 | 8 |
| | 3.00 | 0 | 0 | 7 | 7 |
| Total | | 4 | 9 | 7 | 20 |

Энэ асуултад санал нийлэхгүй гэж хариулсан 4 хүнээс тодруулга авахад яг хүсч байсан хариултад бүрэн дүүрэн хариулаагүй, хуулийн заалтыг буруу хэлсэн, энэ талаар би мэргэшээгүй тул өөр өмгөөлөгчийг яриулна гэсэн хариулт өгсөн гэж хэллээ. Мөн л иргэд энэ утсаар ямар хүрээ хязгаарын дотор зөвлөгөө өгөхийг ойлгоогүйтэй холбоотой. Энэ талаар улсын өмгөөлөгчөөс ярилцлага авахад:

*Шигтгээ*

*Эрх зүйн боловсролыг дэмжих Үндэсний хөтөлбөрийн хүрээнд ХЗДХЯ-наас тусгай дугаар ажиллуулж иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэхээр манай байгууллагад даалгасан. Өмнө нь бид зөвхөн төлбөрийн чадваргүй хүмүүс хууль зүйн туслалцаа, өмгөөлөл үзүүлдэг. Тэр хүмүүс нь ихэвчлэн эрүүгийн гэмт хэрэгт холбогддог. Гэтэл бид энэ үйлчилгээний хүрээнд өөр бусад салбарын асуудлаар зөвлөгөө өгөх болсон. Хэдийгээр бид анхан шатны зөвлөгөө өгөх ёстой ч иргэд энэ талаар ойлгож хүлээж авдаггүй. Мөн биднийг шүүх хуралтай, автомашин барьж байхад, гэртээ амарч байхад хүртэл залгадаг.*

**Хүснэгт 36. Миний асуудлыг шийдвэрлэж өгөхөд тусалж чадах юм гэдэгт би итгэлтэй байсан**

| | | санал нийлэхгүй байна | дунд зэрэг | бүрэн санал хийлж байна | Total |
|---|---|---|---|---|---|
| ethic | 1.00 | 3 | 0 | 0 | 3 |
| | 2.00 | 1 | 9 | 0 | 10 |
| | 3.00 | 0 | 0 | 7 | 7 |
| Total | | 4 | 9 | 7 | 20 |

Энэ асуултын хувьд сэтгэл ханамжийн дээд түвшинг илтгэх үзүүлэлт бөгөөд оролцогсод өмнөх үйлчилгээний хүртээмжээс өндөр үнэлгээ өгсөн байна. Санал нийлэхгүй гэж хариулсан 4 хүн өмнөх асуултандаа ханамжгүй байсан тул шууд үгүй гэсэн хариултыг сонгож байв.

Харилцаа, ёс зүй:

**Хүснэгт 37. Харилцааны хувьд найрсаг байсан**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | санал нийлэхгүй байна | 3 | 15.0 | 15.0 | 15.0 |
| | дунд зэрэг | 10 | 50.0 | 50.0 | 65.0 |
| | бүрэн санал хийлж байна | 7 | 35.0 | 35.0 | 100.0 |

| Total | 20 | 100.0 | 100.0 | |
|---|---|---|---|---|

Улсын өмгөөлөгчийн харилцаа, ёс зүйн талаар ноцтой гомдол, мэдээлэл өгөөгүй бөгөөд санал нийлэхгүй гэж хариулсан 3 оролцогчийн хувьд эргээд ярина гээд яриагүй, мөн хуралтай байна гээд утсаа салгасан гэсэн хариултууд өгч байв.

Үйлчилгээний орчин:

**Хүснэгт 38. Техникийн хувьд асуудалгүй байсан**

| | | Техникийн хувьд асуудалгүй байсан | | | Total |
|---|---|---|---|---|---|
| | | санал нийлэхгүй байна | дунд зэрэг | бүрэн санал хийлж байна | |
| framework | 1.00 | 3 | 0 | 0 | 3 |
| | 2.00 | 0 | 10 | 0 | 10 |
| | 3.00 | 0 | 0 | 7 | 7 |
| Total | | 3 | 10 | 7 | 20 |

Утсаар ярих үед дуу чимээ орж ирэх, тасалдах зэрэг асуудлууд байсан уу гэхэд тийм асуудал харьцангуй бага байсан гэж хариулсан. Мөн л өмнөх асуултад сэтгэл ханамжгүй байсан 3 хүн санал нийлэхгүй гэсэн хариултыг сонгосон. Тодорхой шалтгаан, тайлбараа хэлээгүй болно.

**Нэгдсэн үнэлгээ**

**Хүснэгт 39. Сэтгэл ханамжийн хамаарал**

| Хамаарал | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Model | | Unstandardized Coefficients | | Standardized Coefficients | t | Sig. |
| | | B | Std. Error | Beta | | |
| 1 | (Constant) | 2.483 | .511 | | 4.861 | .000 |
| | access | .434 | 1.000 | .430 | .433 | .670 |
| | quality | -1.860 | .994 | -1.944 | -1.871 | .080 |
| | framework | 1.720 | 1.486 | 1.720 | 1.158 | .264 |
| a. Dependent Variable: Үйлчилгээний сэтгэл ханамж ямар байсан бэ | | | | | | |

Хүснэгтээс харахад хууль зүйн зөвлөгөөг утсаар авсан иргэдийн сэтгэл ханамжийн түвшин өндөр байна. Энэ хэсэгт улсын өмгөөлөгчийн харилцаа, ёс зүй, үйлчилгээний орчин гэсэн үзүүлэлтүүд сэтгэл ханамжид хүчтэй нөлөөлөл үзүүлэхгүй хэвийн утга авсан байна. Утсаар шууд биечлэн санал асуулга явуулахад хүндрэлтэй тул иргэд тав тухтай санал өгөхөөс цааргалж хурдан хариулж байсан тул үнэлгээний оновчтой байдалд эргэлзэж байна.

Нэгдсэн дундаж үнэлгээ нь 80 байна.

# ХОЁРДУГААР ХЭСЭГ. БАЙГУУЛЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

## 2.1. Төвийн чиг үүрэгт хийсэн шинжилгээ

Төвийн чиг үүргийн шинжилгээ хийхдээ Засгийн газрын 22 дугаар тогтоолоор баталсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ыг ашиглах ба менежментийн онол арга зүйг удирдлага болгосон.

"Чиг үүргийн шинжилгээ" гэж хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид төрийн байгууллагын чиг үүргийг хэрхэн тогтоосон, түүнд хамаарах эрх зүйн орчин болон бодлого стратеги, хөтөлбөр, бүтэц зохион байгуулалт, төсөв, зардалд зохих арга зүй ашиглан иж бүрэн дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

Менежмент талаас нь авч үзвэл байгууллага бол гадаад ба дотоод орчноос бүрдэнэ.

**Хүснэгт 40. Байгууллагын гадаад болон дотоод орчин**

| Гадаад орчин | Дотоод орчин |
|---|---|
| Улс төр- хууль эрх зүйн орчин | Зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт |
| Эдийн засгийн хүчин зүйл | Удирдлага ба ажилтан |
| Нийгэм-соёлын хүчин зүйл | |
| Технологийн хүчин зүйл | |

*Төвийн гадаад орчинд хийх шинжилгээ:*

Төвийн эрх зүйн байдал:

Монгол улсын Үндсэн хуулинд:

Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, .........өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй......, Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй. Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд заасны дагуу хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ[2] гэж тус тус заасан.

[2] Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14, 50 дугаар зүйл,

Тиймээс шүүн таслах ажиллагааг бүрдүүлэгч гурван тал болох Шүүх, Прокурор, өмгөөллийн байгууллагын эрх зүйн байдлыг хууль тогтоогч ердийн хуулиараа нарийвчлан тодорхойлохдоо тэнцвэртэйгээр зохицуулах ёстой. Харин өнөөгийн нөхцөлд байдалд дүн шинжилгээ хийхэд шүүн таслах ажиллагааны нэг тал болох өмгөөлөл, хууль зүйн туслалцааны эрх зүйн орчин бусад хоёр тал болох шүүх, прокуроротой харьцуулахад нь нэгдмэл бодлого, хэрэгжилтийн түвшинд харилцан уялдаатай байж чадаагүй байна. Хэдийгээр хүн өөрийгөө өмгөөлөх эрх нь чөлөөтэй байдаг ч хүн бүрт энэ энэ эрхээ эдлэх боломж мэдлэг, ур чадвар, санхүүгийн хувьд харилцан адилгүй. Өмгөөллийн харилцааг зохицуулж хуулиуд болох Хуульчдын эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хуулиудад хэдийгээр нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаагаар гэж зохицуулалт байгаа ч төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчлэх гол байгууллага нь Хууль зүйн туслалцааны төв гэх төрийн байгууллага байна. Энэ байгууллагыг төрийн байгууллагын статусаар ажиллуулахыг төр хүсч байгаа бол түүнийг шүүн таслах ажиллагааны бусад хоёр талаас эрх зүйн байдлыг нь дордуулахгүй авч явах үүрэгтэй гэж үзэж байна. Өнөөгийн нөхцөлд байдал Монгол улсад ядуурлын индекс буурахгүй байгаа, ажилгүйдэл, ядууралтай шууд хамааралтай гэмт хэргийн шалтгаан нөхцөл чанарын буурулт харагдахгүй байгаа нөхцөлд тус Төвийн эрх зүйн байдлыг тодорхой болгож, үйлчилгээний үр нөлөөг сайжруулах шаардлагатай.

Төвийн талаар тодруулбан авч үзвэл:

Хууль зүйн үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөг сайжруулах зорилгоор "Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг Засгийн газрын 2006 оны 263 дугаар тогтоолоор баталсан. Эрх зүйн туслалцааны төвүүд байгуулагдахаас өмнө төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажил нь Монголын өмгөөлөгчдийн холбоогоор дамжин Хууль зүй, дотоод хэргийн яамны удирдлага дор зохион байгуулагддаг байсан.

Хөтөлбөрт Эрх зүйн туслалцааны төвийг 2011 он гэхэд нийт аймаг, нийслэлийн дүүрэгт үе шаттайгаар байгуулсан байхаар заасан. Эрх зүйн туслалцааны төвүүдийн үйлчилгээг нэвтрүүлэх замаар хууль зүйн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор 2008 оноос Хууль зүй, дотоод хэргийн яам Нээлттэй нийгэм форум, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн "Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх" төсөл, аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Эрх зүйн туслалцааны төв"-ийг бүх аймаг, дүүрэг

болон зарим суманд байгуулан ажиллуулж эхэлсэн байна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлсэн туршлага, хүний нөөц, материаллаг баазад түшиглэн төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлын эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор "Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль"-ийг Улсын Их Хурлаас 2013 онд баталж, 2014 оны 1 сарын 1 нээс хэрэгжиж эхэлжээ.

ТЧЯҮХЗТТХ-ийн 3.1.6-д "хууль зүйн туслалцааны төв" гэж төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллагыг хэлнэ гэж тодорхойлсон.

Төвийн удирдлага, зохион байгуулалтыг хуульд дараах байдлаар тодорхойлж өгсөн. Үүнд:

1.Төв нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байна.

2.Төв нь ажлын алба, салбараас бүрдэнэ.

3.Төвийн ажлын алба нь хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулна

4.Төвийн салбарт улсын өмгөөлөгч ажиллана гэжээ.

Улсын өмгөөлөгчийн эрх зүйн байдлыг энэ хууль болон Хуульчдын эрх зүйн байдлын тухай хуульд мөн зохицуулж өгсөн.

Мөн Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд хууль зүйн туслалцаа авах эрх бүхий хүнд хамаардаг.

Төвөөс хэрэглэгчдэд үзүүлэх хууль зүйн туслалцаа нь дараах төрөлтэй байна:

1.хууль зүйн зөвлөгөө өгөх;

2.өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх.

Өмнөх Засгийн газрын хөтөлбөрийн 5.3.10.Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ гэж заасан ба одоо энэ хуулийн төсөл боловсруулах шатандаа байна.

Цаашид төвийн эрх зүйн орчныг сайжруулахад Үндсэн хуулийн үзэл баримтлалаас гадна, Алсын Хараа-2050, Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн төлөвлөгөө, 2020-2024 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн зорилт, дурдагдсан зорилт, зүйл заалтай уялдуулах шаардлагатай.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний 2015 оны 9 дүгээр сард зохион байгуулагдсан чуулга уулзалтаар 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлт бүхий 2030 он хүртэлх Дэлхийн Тогтвортой

хөгжлийн хөтөлбөрийг баталсан. Энэ тогтвортой хөгжлийн зорилтын нэгдүгээрт бүх төрлийн ядуурлыг устгах гэж тодорхойлсон. Энэ зорилттой Төвийн үйл ажиллагаа хэрхэн холбогддогийг дараах судалгаанд үндэслэж тайлбарлая.

Монгол улсын хувьд ядуурлын хамралтын хүрээ 2019 оны байдлаар хөдөөд 30.8 хувь, хотод 27.2 хувь буюу хөдөөд хотоос өндөр байна[3]. Ядуурлын түвшинд байгаа 904.9 мянган хүний 378 мянга нь хотод амьдарч байна. Бүр тодруулбал, нийслэлийн таван хүн тутмын хоёр нь ядуурлын түвшинд хамрагджээ[4].

2017 онд Удирдлагын академийн судалгааны багийн "Нийгмийн дунд давхрааны төлөв байдал: Улаанбаатар хотын өрхийн жишээгээр" сэдэвт судалгаанаас иш татвал:

Улаанбаатар хотын дунд давхрааны өрхийн сарын дундаж орлогын түвшин 1,145,950 төгрөг байгаа нь ҮСХ-ноос 2017 оны эхний дөрвөн сарын байдлаар тооцсон өрхийн орлогын дүнтэй ойролцоо, ердөө 6.6 хувийн ялгаатай түвшинд байна. Өрх нийт орлогынхоо дийлэнхийг цалингийн эх үүсвэрээс бүрдүүлж байгаа бөгөөд тэтгэвэр, тэтгэмж, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, ХААн үйл ажиллагаа, түрээс/хүүгийн орлого зэрэг нь өрхийн нийт орлогод багахан хувь нэмэр оруулж байна.

Өрхийн орлогын эх үүсвэрийн дунджийг тооцоход 1.6 гарсан нь Улаанбаатар хотын дунд давхрааны өрх 1-2 орлогын эх үүсвэртэй байгааг 152 харуулж байна. Энэ нь өрхийн орлого, санхүүгийн баталгаат байдал эмзэг байдалтай болохыг илтгэв. Судалгаанд хамрагдсан өрхийн гишүүд орлогын хүрэлцээт байдлаа дундаж түвшинд үнэлэх хандлага илүүтэй байсныг гурван өрх тутмын нэг нь хуримтлал бий болгох боломжгүй гэсэн судалгааны дүнтэй холбон тайлбарлаж болохоор байна. Цаашилбал, нийт өрхийн 63.3 хувь нь урт, богино хугацааны, их, бага хэмжээний зээлтэй байв. Үүнээс үзэхэд, дундаж давхрааны өрх нь хөрөнгө, эд хогшил худалдан авах, бизнес эрхлэх, санхүүгийн хэрэгцээгээ хангахад зээлийн хөрөнгийг гол эх үүсвэр болгон ашиглах хандлагатай байна. Гэвч зээлийн хүү өндөр, хугацаа богино байгаа нь зээлийн эргэн төлөлтийн төлбөр өрхийн нийт орлого, амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна гэж гурван жилийн өмнө дүгнэж байжээ. Харин одоо Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан дунд давхаргын бүлгээс хамгийн багадаа 4,3 хувь нь

[3] ҮСХ-ний тайлангаас
[4] ҮХС-ны сайтаас

ядуурлын шугамаас доош гарах магадлалтай гэж зарим судлаачид таамаглал дэвшүүлж байна.

Ядууралтай байнга дагалдаж байдаг асуудал бол ажилгүйдэл, гэмт хэрэг байдаг. Жишээ ЦЕГ[5]-ын 11 сарын гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн ажил эрхлэлт, боловсрол, гэмт хэрэг гарсан тоогоор ангилж гаргасан хүснэгтээс түүвэрлэн зургаар үзүүлбэл:

**Зураг 1. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн ажил эрхлэлт**




Жишээбэл: нийт 190000 төрийн албан хаагчаас 479 хүн 11 сард гэмт хэрэг холбогдсон байна. Ажилгүй гэж бүртгүүлсэн иргэдээс 18300 нь ажилгүй байна[6].

**Зураг 2. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн боловсролын түвшин**

[5] police.gov.mn
[6] 2020 оны 9 сарын байдлаар




Өрхийн мэдээллийн санд амьжиргааны доош шугаманд орсон өрхийн гишүүдийн дунд ажилгүй, боловсролын түвшин бага байдаг. Энэ жилийн хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд хамрагдсан улсын өмгөөлөгч авсан 20 хүний дунд ажилгүй, боловсролын түвшин өндөр биш байна(Хүснэгт 8-аас харна уу).

Нийслэлийн хэмжээнд төвийн дүүргээр нь гэмт хэрэгт холбогдсон байдлыг нь авч үзвэл:

**Зураг 3. Дүүргийн харьцуулалт**




Эндээс Сонгинохайрхан дүүргийг тодотгож авч үзвэл: СХД-ийн 321000 иргэнтэй, нийт өрхийн 26.2 хувь нь ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй байна. Эдгээр ядуу өрхөд нийт 148.6 мянган амьдарч байгаа нь дүүргийн нийт хүн амын 46 хувь болж байна. Өөрөөр хэлбэл, СХД-ийн нийт хүн амын 46 хувь нь

сарын 146.1 мянган төгрөгнөөс доош хэрэглээтэй буюу ядуу амьдарч байна[7]. Бусад дүүргийн энэ үзүүлэлттэй харьцуулахад хамгийн өндөр тоог эзэлдэг.

2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийг хороогоор авч үзвэл, 2018 оны байдлаар 16, 28, 10-р хороодод хамгийн бага байгаа бол 6, 22, 31-р хороодод хамгийн их байна. Хамгийн их гэмт хэрэг гарсан хороод болох 22, 31 хороо нь дүүргийн нийт 32 хорооноос ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй өрхтэй хороодыг жагсаахад эхний нэг, болон наймдугаарт эрэмбэлэгдсэн байна[8].

Иймд тус дүүрэгт ажиллах улсын өмгөөлөгч тоо болон бусад төвийн дүүргүүдтэй харьцуулж үзвэл:

**Хүснэгт 41. Дүүргүүдийг харьцуулах нь**

| Дүүрэг | Тоо |
|---|---|
| Баянзүрх | 5 |
| Баянгол | 4 |
| Сонгинохайрхан | 3 |
| Сүхбаатар | 4 |
| Хан-Уул | 4 |
| Чингэлтэй | 2 |

Хүн ам, ядуу өрх, гэмт хэргийн тоогоор нийслэлд өндөр үзүүлэлтэй энэ дүүрэгт 3 улсын өмгөөлөгч ажилладаг гэдэг учир дутагдалтай байна. Мөн эдгээр улсын өмгөөлөгчид тусгай дугаар бүхий утсаар мөн, албаны өрөөндөө биечлэн хууль зүйн зөвлөгөө өгнө.

Цаашилбал, Тогтвортой хөгжлийн 1 дүгээр зорилгын зорилт 1.4 –т 2030 он эрэгтэй, эмэгтэй хүн бүр, ялангуяа ядуу, эмзэг бүлгийнхэн эдийн засгийн нөөц боломжийг эрх тэгш авч ашиглах, түүнчлэн нийгмийн үндсэн үйлчилгээ, газар болон бусад хэлбэрийн эд хөрөнгө өмчлөх, захиран зарцуулах, өв залгамжлах, байгалийн баялаг, зохих шинэ технологи, санхүүгийн үйлчилгээ, түүний дотор бичил санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх ёстой гэж заасан байдаг. Энэ хүрээнд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт: 4.4.5.Гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, хүүхдийн тэтгэмж тогтоох болон газар өмчлөх эрх нь хөндөгдсөн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж тус заасан. Хэрэв энэ үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн зохицуулалт бий болбол улсын

[7] НҮБХХ-ийн "Тогтвортой хөгжлийн зорилго" төсөл, 2019 он. тайлангаас
[8] Мөн энд

өмгөөлөгчийн ажлын ачаалал, түүний мэргэшсэн байдал зэрэгт олон өөрчлөлт бий болно.

**Анхаар:** Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд одоо байгаа Төвийн төсөв, хүний нөөцөд хангалттай чадавхи байхгүй байна. Өнөөдрийн байдлаар нийт 55 улсын өмгөөлөгч ажиллаж байна.

Өнгөрсөн 6 жилийн хугацаанд Төвөөс үзүүлсэн улсын өмгөөлөл авсан үйлчлүүлэгчийн тоог үзүүлбэл:

**Хүснэгт 42. Өмгөөллийн үйлчилгээ (2014-2020)**

| Он | Тоо (хүнээр ) |
|---|---|
| 2014 | 2102 |
| 2015 | 3145 |
| 2016 | 2749 |
| 2017 | 2904 |
| 2018 | 3003 |
| 2019 | 3178 |
| 2020 оны 3 улирлын байдлаар | 2528 |

*Эх сурвалж. Төвийн тайлангаас*

Тодруулбал, Төвд ажиллаж байгаа улсын өмгөөлөгч нар шүүхэд төлөөлөх эрхтэй нийт 3251 өмгөөлөгчдийн 3 хүрэхгүй хувийг эзэлж байгаа боловч шүүхээр шийдвэрлүүлсэн эрүүгийн хэргийн 30 орчим хувьд өмгөөлөл хийсэн байна[9]. Энэ нь улсын өмгөөлөгч нар хэр их ачаалалтай ажиллаж байгаа нь харагдаж байгаа бөгөөд ядуурлын түвшин өндөр байгаа өнөөгийн нөхцөлд хэрэгцээ шаардлагын тоо буурахгүй юм.

2018 онд Засгийн газраас баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг зохион байгуулж, хэрэгжүүлэх ХЗДХЯ –нь харьяа байгууллагууд болох Хууль зүйн Үндэсний Хүрээлэн, Хууль зүйн туслалцааны төвд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг даалгасан. Үүний дагуу Төв нь иргэдэд үнэ төлбөргүй утас ажиллуулах, нээлттэй өдөр зохион байгуулах үүргийг гүйцэтгэнэ. Энэ талаар улсын өмгөөлөгчийн хийсэн ярилцлагыг 1.1 дүгээр бүлгээс харна уу. Гэтэл ТЧЯҮХЗТТХ-ийн 17.2.Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаанд энэ хуульд заасан буюу төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйл ажил ажиллагаанаас бусад үйл ажиллагааг явуулахыг хориглоно гэж заасан.

[9] Төвийн албаны тушаалтантай хийсэн ярилцлагаас

*Хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө авсан иргэдийн тоо бараг 60 мянга шахаж байна.*

*Холбогдох албан тушаалтны ярилцлагаас*

Энэ үйлчилгээний хэрэглэгчийн сэтгэл ханамжийг 1.2 дугаар бүлгээс харна уу.

Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд зааснаар 7.4.6.хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж заасан.

Дээр дурдсан улсын өмгөөлөгчийн ажлын ачаалал, өнөөгийн мэргэшсэн байдлаас харахад НҮБ-ын зорилт, Монгол улсын 5 жилийн үндсэн чиглэлийн дагуу дахиад ачаалал авахаар харагдаж байна.

Байгууллагын чиг үүрэг, эрх зүйн орчны талаар улсын өмгөөлөгч, ажлын албаны албан хаагчдаас саналыг нь анкет бөглүүлж авсан.

**Хүснэгт 43. Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн орчин хангалттай бүрдсэн (улсын өмгөөлөгч)**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | үгүй | 8 | 14.5 | 14.5 | 14.5 |
| | дунд зэрэг | 25 | 45.5 | 45.5 | 60.0 |
| | тийм | 17 | 30.9 | 30.9 | 90.9 |
| | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | 5 | 9.1 | 9.1 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

Нийт өмгөөлөгчдийн 42 буюу 75 хувь нь хангалттай түвшинд бүрдсэн гэж дүгнэсэн байна. Харин холбогдох хууль, бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийхэд өмнөх онуудад дэвшүүлж байсан зорилтууд энэ онд бүрэн гүйцэтгэл хангаагүй байна.

*Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон тус үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд "Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ", "Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа*

*үзүүлэх хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ", "Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах шаардлагатай нийгмийн зорилтот бүлгийн судалгааг гаргана", "Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлыг 2017-2018 онд гүйцэтгэж Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх ажлыг 18 онд хийнэ" гэж тус тус төлөвлөсөн байна.*

*Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлыг Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл батлагдсаны дараа хуульд нийцүүлэн хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулахаар төлөвлөсөн бөгөөд "Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, хөтөлбөрийн төслийг боловсруулаад байна.*

*Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд буюу эрүүгийн хэргийн хохирогч, иргэн, захиргааны хэргийн төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн холбогдогчдод үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх оновчтой бүтцийг бий болгох талаар санал боловсруулж Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөлд тусгасан бөгөөд Хууль зүйн туслалцааны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх зардлыг урьдчилан тооцож Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн байна.*

*2019 оны хэрэглэгчийн үнэлгээний тайлангаас*

**Хүснэгт 44. Улсын өмгөөлөгчийн тоо ихсэж, иргэдэд үйлчлэх ачаалал буурсан**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | үгүй | 31 | 56.4 | 56.4 | 56.4 |
| | дунд зэрэг | 15 | 27.3 | 27.3 | 83.6 |
| | тийм | 8 | 14.5 | 14.5 | 98.2 |
| | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | 1 | 1.8 | 1.8 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

Санал асуулгад оролцогсон улсын өмгөөлөгчдийн 80 гаруй хувь нь үгүй, дунд зэрэг гэдэг хариултыг сонгожээ.

Нэг өмгөөлөгч дунджаар 27-60, сард тогтмол 20 орчим хэрэгт өмгөөлийн үйлчилгээ үзүүлдэг. Энэ ажил дээр тусгай утсаар болон "Иргэдэд үйлчлэх танхим"-д ажиллан иргэдэд хууль зүйн зүйн зөвлөгөө, туслацаа өгдөг байна.

*Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл батлагдвал тодорхой гэмт хэргийн хохирогч, зарим төрлийн иргэний хэргийн оролцогчид зэрэг үйлчлүүлэгчдийн төрөл нэмэгдэх бөгөөд ажлын ачаалал улам ихсэх юм. Иймд ХЗТТ нь цаашид улсын өмгөөлөгчийн орон тоог нэмэх асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр гаргуулахад бэлтгэж Хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдах эсэхээс үл хамааран Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд болон хамгийн ачаалал ихтэй байгаа аймгуудад улсын өмгөөлөгчийн орон тоог нэмэх арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.*

*2019 оны хэрэглэгчийн үнэлгээний тайлангаас*

Өмнөх жилийн тайланд дурдсан ачаалал чанарын хувьд буураагүй нь өмгөөлөгчдөөс авсан судалгаанаас харагдаж байна.

Нэг өмгөөлөгчийн ажлын байрны зураглал хийж үзвэл:

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, шүүхэд төлөөлөх;

- Урьдчилсан хэлэлцүүлгийн хурал
- Гэм буруугийн хурал
- Ялын хурал
- Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хурал /15-30 хоног/-д оролцох

2. Үйлчлүүлэгчийн хэргийн материал, хавтаст хэрэгтэй танилцах /Дунджаар 1 хэрэгт 2-100 хавтас, түүнээс дээш/

3. Мөрдөн байцаах ажиллагаанд оролцох

4.Цагдан хоригдож буй үйлчлүүлэгчтэй уулзах /ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461, Хаалттай хорих анги 409 дүгээр анги руу очиж өдөрт 4-13 үйлчлүүлэгчтэй уулздаг/

5.Өөрийн салбарын хэмжээнд иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, хууль сурталчлах ажилд оролцох

6.Шүүх, прокурорт хүсэлт, гомдол гаргах

7.Захиргааны бусад чиг үүргийг хэрэгжүүлэх гэх мэт үйл ажиллагааг өдөр тутам хэрэгжүүлэн, ажлын өндөр ачаалалтай ажилладаг болно[10].

Гэтэл Өмгөөлөгчдийн болон Хуульчдын холбооны хамгийн их үйлчлүүлэгчтэй өмгөөлөгч жилд дунджаар 25 эрүүгийн хэрэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг

---

[10] Төвийн хийсэн тайлангаас

байна[11]. Тиймээс ажлын ачаалал их байх тул хэрэглэгчдэд үйлчлэх үйлчилгээний чанарт нөлөөлөх нөхцөл байдал үүсч байна.

Энэ үйлчилгээний талаарх хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг 1.1 дүгээр бүлгээс харна уу.

**Санал:** Иймд хэрэв тус Төвийн улсын өмгөөллөгчдийг төлбөрийн чадваргүй яллагчдад хууль зүйн зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж буй үйлчилгээг өргөтгөх бол Төвийн төсөв, орон тоог нэмэгдүүлэх, улсын өмгөөлөгчийн цалин хөлсийг нэмэх, сонгон шалгаруулалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага гарч ирж байна. Мөн "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх Үндэсний хөтөлбөрт заасан ажлын хүрээнд бүх иргэдэд тусгай утас ажиллуулах ажлыг Хууль зүйн Үндэсний хүрээлэнд төвлөрүүлэх нь үйлчилгээний чанарт чухал юм.

Захиргааны ажилтны хувьд:

**Хүснэгт 45. Ажлын ачаалалд тохирсон бүтэц, орон тоотой**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Огт санал нийлэхгүй байна. | 1 | 14.3 | 14.3 | 14.3 |
| | Санал бараг нийлэхгүй байна | 2 | 28.6 | 28.6 | 42.9 |
| | Дунд зэрэг | 3 | 42.9 | 42.9 | 85.7 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 1 | 14.3 | 14.3 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

Мөн гүйцэтгэж буй ажлын ачаалалд тохирсон бүтэц орон тоо бий болоогүй гэдгийг баталсан байна.

Төвийн эдийн засгийн хүчин зүйлс:

Төвийн хувьд төсвийн байгууллага төсвөөс санхүүжилт авдаг. Гэхдээ өмнөх хэсэгт гарсан одоо болон цаашид нэмэгдэх чиг үүргүүдэд нэг тэрбум 300 сая төгрөгөөр явуулах боломжгүй байна. Энэ талаар өмнөх хэсэгт албан хаагч, удирдах албан тушаалтан ярилцлага, санал асуулгад мөн хэлж байсан.

**Санал:** Иймд төсвийн шинжилгээг мэргэжлийн шинжээчээр хийлгэнэ үү.

Нийгэм-соёлын хүчин зүйлс: энэ талаар байгууллагын гадаад гэхээсээ дотоод орчинтой холбох нь зүйтэй гэж судлаачад үзлээ.

---

11 .......өмгөөллийн товчооны өмгөөлөгчтэй хийсэн ярилцлагаас

## 2.2. Байгууллагын дотоод орчны шинжилгээ

*Төвийн эрхэм зорилго*

Төвийн эрхэм зорилго нь төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгжилтийг холбогдох дээд байгууллага, удирдлагын өмнө хариуцан тайлагнаж, эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй яллагдагчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх, иргэдэд сургалт, сурталчилгаа хийх үйл үйл ажиллагааг зохистой удирдан зохион байгуулна гэжээ. ( www.lac.gov.mn-д буй мэдээлэлд байгууллагын эрхэм зорилго, үндсэн үүрэг давхцсан агуулгатай байна).

Эрхэм зорилго гэж тодорхойлсон агуулга нь оновчгүй, тухайн байгууллагын үндсэн үүргийн шинжтэй байна.

**Санал:** Байгууллагын эрхэм зорилго нь дараах стратегийн суурь, тулгуур асуудлуудыг агуулсан байвал зохино. Үүнд:

- байгууллагын өрсөлдөх чадварыг тасралтгүй дээшлүүлэх
- хэрэглэгчийг дээдлэх, эрэлт хэрэгцээг нь хангах
- байгууллагын үнэт зүйл, соёлыг бэхжүүлж, хөгжүүлэх
- албан хаагчдыг хөгжүүлэх, өндөр бүтээмжтэй ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх зэрэг болно.

Нэгээс хоёр өгүүлбэрээс хэтрэхгүй байвал зүгээр байдаг.

Эрхэм зорилгоо хэрхэн тодорхойлох вэ? Хамгийн үр дүнтэй арга бол ажилтнуудын дунд ХЭЛЭЛЦҮҮЛЭГ зохион байгуулах юм.

Эрхэм зорилгоо зөв тодорхойлж чадсан байгууллагын соёл, дотоод уур амьсгал сайжирч хэрэглэгчдэд чиглэсэн үйлчилгээний чанар дээшилдэг. Мөн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах сэтгэл ханамжид нөлөөлдөг. Энэ талаар улсын өмгөөлөгч, захиргааны ажилтнуудаас судалгаа авсан юм.

**Хүснэгт 46. Тогтвортой ажиллана гэсэн итгэл дүүрэн байна(улсын өмгөөлөгч)**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | үгүй | 3 | 5.5 | 5.5 | 5.5 |
| | дунд зэрэг | 14 | 25.5 | 25.5 | 30.9 |
| | тийм | 37 | 67.3 | 67.3 | 98.2 |
| | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | 1 | 1.8 | 1.8 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 47. Тогтвортой ажиллана ба насны хамаарал (улсын өмгөөлөгч)**

| | | Тогтвортой ажиллана гэсэн итгэл дүүрэн байна. | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | үгүй | дунд зэрэг | тийм | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | Total |
| Таны нас | 20-35 | 1 | 5 | 11 | 0 | 17 |
| | 36-45 | 1 | 4 | 14 | 1 | 20 |
| | 46 -59 | 0 | 4 | 8 | 0 | 12 |
| | 60-аас дээш | 1 | 1 | 4 | 0 | 6 |
| Total | | 3 | 14 | 37 | 1 | 55 |

Энэ үзүүлэлтэд 20-45 насныхан 33 хүн буюу дийлэнх авч үзжээ.

Сэтгэл ханамжид нөлөөлдөг хүчин зүйлс болох ажлын ачаалал гэсэн өмнөх асуултад сэтгэл ханамжгүй гэсэн тоо өндөр байсан ч (Хүснэгт 44) цаашдаа тогтвор суурьшилтай ажиллана гэдэгтэй итгэл дүүрэн байна гэсэн хариултыг 60-ээс дээш сонгосон зэрэг шалтгаанд байгууллагынхаа үнэт зүйлс, эрхэм зорилгод чин үнэнч хүмүүс харин сөрөг шалтгаанд байнгын ажлын байртай, тогтмол цалин хөлс байх гэсэн сэдэлттэй холбогддог. Энэ талаар холбогдох Төвийн холбогдох удирдлагаас лавлахад:

*Шигтгээ*

*Улсын өмгөөлөгчийн сонгон шалгаруулалтад оролцогчид ихэвчлэн хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, ажлын туршлагагүй, туршлага хуримтлуулах зорилготой, эсхүл хуулийн байгууллагаас тэтгэвэрт гарсан иргэд оролцдог.*

**Хүснэгт 48. Би байгууллагынхаа үнэт зүйлс, нэр хүндийг дээдлэн бахархан ажилладаг (Захиргааны ажилтан )**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Дунд зэрэг | 2 | **28.6** | 28.6 | 28.6 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 3 | **42.9** | 42.9 | 71.4 |
| | Бүрэн санал нийлж байна. | 2 | **28.6** | 28.6 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

Захиргааны ажилтнууд байгууллагынхаа үнэт зүйлс 80 гаруй хувь нь хүндэтгэлтэй ханддаг гэж үзлээ.

**Хүснэгт 49. Би байгууллагадаа цаашдаа ч тогтвортой ажиллана гэж боддог(Захиргааны ажилтан )**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Санал бараг нийлэхгүй байна | 2 | 28.6 | 28.6 | 28.6 |
| | Дунд зэрэг | 1 | 14.3 | 14.3 | 42.9 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 2 | 28.6 | 28.6 | 71.4 |
| | Бүрэн санал нийлж байна. | 2 | 28.6 | 28.6 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

*Төвийн бүтэц, зохион байгуулалт:*

Байгууллагын зорилгодоо хүрэх, үр ашигтай ажиллах эсэх нь оновчтой бүтэц зохион байгуулалтаас ихээхэн шалтгаалдаг. Оновчтой зохион байгуулалтыг бий болгохын тулд байгууллагын стратеги зорилго, хүрээлэн байгаа орчин, дотоод хүчин зүйлс болох технологи, байгууллагын хэмжээ зэргийг харгалзан үзэх шаардлагатай.

**Санал:** Төвийн үйл ажиллагаа энэ тайлангийн 2.1-д дурдагдсан хөтөлбөр, хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар шинээр чиг үүргүүд нэмэгдэх аваас байгууллагын стратегийн баримт бичигтэй энэ талаар нарийвчлан тусгана уу.

## ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨВИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




Байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тодорхойлохдоо дараах үндсэн зарчмыг баримтлана.Байгууллагын Стратеги төлөвлөгөөг энэ оны 10 дугаар сард боловсруулж, ХЗДХЯ –д хүргүүлсэн байна. Иймд Төвийн дүрэмд буй зохицуулалтад шинжилгээ хийв.

**Хүснэгт 50. Төвийн бүтцийн матрицыг шалгасан нь**

| Шалгуур | Төвийн бүтэц |
|---|---|
| Тодорхой томъёолсон зорилготой байх | Байгууллагын эрхэм зорилготойгоо уялдсан байх нь зүйтэй. Хэрэв дээр дурдсан үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрт дурдсан чиг үүрэг нэмэгдэх бол зорилгоо **Төлбөрийн чадваргүй иргэдэд бүх салбарын хууль зүйн зөвлөгөө өгөх, улсын өмгөөлөл үзүүлэх, тэднийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бид хийнэ.** |
| | Хэрэв ингэж эрхэм зорилгыг тодорхойлбол дараах бүтцийн матриц байж болох юм. |



| | |
|---|---|
| Удирдлагын зохион байгуулалтын бүтэц аль болох энгийн байх | Захиргаа удирдлагын нэгжид хүний нөөц, захирлын ажлын алба, туслах өмгөөлөгч нар, санхүү, үйлчилгээ, архив зэргийг өөртөө багтаасан дарга нь шууд захиралд ажлаа тайлагнана. Хууль зүйн туслалцаа нэгжид улсын ахлах өмгөөлөгч, улсын өмгөөлөгч нараас бүрдэнэ. Энэ нэгжийн даргыг захирал томилно. Өнөөгийн хуулиар Төвийн захирал ажлын албаны дарга байна гэвэл чиг үүрэг нэмэгдэх тусам ачаалал нэмэгдэх үр ашиггүй удирдлагын хэв маяг руу орох эрсдэлтэй. |
| Мэдээллийг яв цав дамжуулах буцах холбоог хангах | Одоо байгаа бүтэц нь дээрээс босоо чиглэлд байх тул буцах холбоог сул гэж дүгнэллээ. |
| Захирамжлал нэгдмэл байх; | Хангагдсан байна. |
| Удирдах нормтой байх; | Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2019 оны "Аргачлал, загвар батлах тухай" 47 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын дагуу төрийн захиргааны 4 албан хаагчтай 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хууль зүйн туслалцааны төвийн захирлын 2015 оны "Журам батлах тухай" А/22 дугаар тушаалын дагуу нийт 68 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээг дүгнэсэн. |
| Цөөн шатлалтай байх | Орон тоо цөөн тул хангагдсан гэж үзлээ. |

Байгууллагын дотоод бүтэц, зохион байгуулалтад хамаарах гүйцэтгэлийн хяналтын талаар улсын өмгөөлөгчөөс санал асуулга авсан.

**Хүснэгт 51. Байгууллагын ажлын гүйцэтгэлийг тооцох тогтолцоо сайжирсан (улсын өмгөөлөгч )**

| Байгууллагын ажлын гүйцэтгэлийг тооцох тогтолцоо сайжирсан | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
| Valid | үгүй | 8 | 14.5 | 14.5 | 14.5 |
| | дунд зэрэг | 19 | 34.5 | 34.5 | 49.1 |
| | тийм | 25 | 45.5 | 45.5 | 94.5 |
| | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | 3 | 5.5 | 5.5 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

Улсын өмгөөлөгчийн ажлын үр дүнг дүгнэх аргачлалыг ХЗТТ-ийн захирал батлахаар Хууль зүйн туслалцааны тухай хуульд тусгах нь зүйтэй гэсэн саналыг ажлын албаны албан хаагчдын зүгээс өгсөн байна. Мөн улсын өмгөөлөгчийн хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний үр дүнг дүгнэх аргачлалыг мөн л одоог хүртэл батлаагүй, аливаа эрх зүйн зохицуулалтаар зохицуулаагүй байна. Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн хүртээмж, үр нөлөөг тооцох нийтлэг аргачлал Монгол Улсын хэмжээнд байхгүй байгаа тул ХЗДХЯ-наас ийм аргачлалыг баталж, холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнууд хэрэгжүүлж эхлэх шаардлагатай гэж үзэж байна.

*2019 оны хэрэглэгчийн үнэлгээний тайлангаас*

Энэ онд дээрх асуудал хэрхэн шийдэгдсэн талаар эрх бүхий албан тушаалтнаас лавлахад: Хууль зүйн туслалцааны төвийн захирлын 2015 оны "Журам батлах тухай" А/22 дугаар тушаалын дагуу нийт 68 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээг дүгнэсэн. Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг үндэслэн Хууль зүйн туслалцааны төвийн захирлын 2020 оны "Урамшуулал олгох тухай" А/29 дүгээр тушаалаар 66 албан хаагчид улирлын урамшууллыг олгосон.

Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ыг хэрэгжүүлэхээр улсын өмгөөлөгч,

улсын өмгөөлөгчийн туслахад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулахаар ХЗДХЯ-нд хүргүүлсэн гэж тайлбар өгөв.

**Санал:** Байгууллагын зүгээс холбогдох төсвийн дагуу тодорхой ажлууд хийсэн байна. Гэхдээ Төвийн чиг үүргийг өргөтгөх, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд улсын өмгөөлөгч, өнөөгийн ачааллыг багасгах, орон тоо нэмэх, тэдний ажилд ТЧЯҮХЗТТХ-д зааснаар туслалцаа үзүүлэх ажлын албаны албан хаагчдыг чадавхижуулах шаардлагатай байна.

Байгууллагын дотоод бүтцэд хамаарах ажил үүргийн давхардал байгааг захиргааны албан хаагчдаас тодруулахад:

Ажлын албанд ажилладаг 5 албан хаагч байгаагаас 3 нь эрх зүйн ч мэргэжилтэй байна. Ажлын албанд одоо төрийн захиргааны 6 орон тоо сул байна. Чиг үүргийн шинжилгээнд үндэслэн албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын /холбогдох тогтоол гарах хугацааг хүлээсэн/ дагуу боловсруулж, төслийг батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлд 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 1/257 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2020 оны 6 дугаар сард сул орон тооны сонгон шалгаруулалтыг салбар зөвлөлөөс зохион байгуулсан бөгөөд Салбарын мэргэжил, арга зүйн хэлтсийн дарга, Сургалт, сурталчилгаа, хэвлэл мэдээлэл, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтний албан тушаалд 2 албан хаагч тэнцэж томилогдсон. /Бусад албан тушаалын сул орон тоонд хүн бүртгүүлээгүй./[12]

Дээрх 2 албан тушаалд ажиллаж байсан 2 албан хаагч 1 нь /ССХММТХМ/ эрүүл мэндийн шалтгаанаар, 1 нь /СМАЗХД/ өөр албан тушаалд шилжин ажиллахаар чөлөөлөгдсөн.

[12] Холбогдох албан тушаалтнаас аван ярилцлагаас

**Хүснэгт 52. Чиг үүргийн давхардал байхгүй(захиргааны ажилтан)**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Санал бараг нийлэхгүй байна | 2 | **28.6** | 28.6 | 28.6 |
| | Дунд зэрэг | 4 | **57.1** | 57.1 | 85.7 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 1 | **14.3** | 14.3 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

Ажлын албаны албан хаагчдын хувьд чиг үүргийн давхардал байгааг 80 орчим хувь нь зөвшөөрсөн байна.

*Хүний нөөцийн өнөөгийн байдал:*

Хууль зүйн туслалцааны төв нь орон тооны хувьд ажлын албанд 5, үйлчилгээний албан хаагч 3, улсын өмгөөлөгч 55, улсын өмгөөлөгчийн туслах 7, нийт 70 албан хаагчидтай нийслэлийн 8 дүүрэг, 21 аймаг болон хүн ам ихтэй 2 сумыг хамруулан 31 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

1. Улсын өмгөөлөгч:

**Хүснэгт 53. Өмгөөлөгчийн хүйс**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Эрэгтэй | **18** | 32.7 | 32.7 | 32.7 |
| | Эмэгтэй. | **37** | 67.3 | 67.3 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 54. Өмгөөлөгчийн нас**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | 20-35 | **17** | 30.9 | 30.9 | 30.9 |
| | 36-45 | **20** | 36.4 | 36.4 | 67.3 |
| | 46 -59 | **12** | 21.8 | 21.8 | 89.1 |
| | 60-ээс дээш | **6** | 10.9 | 10.9 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 55. Өмгөөлөгчийн ажилласан жил**

| | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Valid | 1 жил дотор | **7** | 12.7 | 12.7 | 12.7 |
| | 2-5 жил | **20** | 36.4 | 36.4 | 49.1 |
| | 6- 10 | **23** | 41.8 | 41.8 | 90.9 |
| | 10-ээс дээш жил | **5** | 9.1 | 9.1 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 56. Өмгөөлөгчийн оршин суугаа газар**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | нийслэл | **18** | 32.7 | 32.7 | 32.7 |
| | Орон нутаг | **37** | 67.3 | 67.3 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

**Санал:** Хүний нөөцийн талаар шинжлэх ухааны үндэслэлтэй, оновчтой, үр нөлөөтэй хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд албан хаагчдын **тоон болон чанарын** нарийвчилсан мэдээлэл, тухайлбал, албан хаагчдын нийгмийн байдал (нас, хүйс, гэр бүл г.м), мэдлэг чадвар (боловсрол, мэргэжил, ажлын туршлага), хүсэл тэмүүлэл, үнэт зүйл ( ажилд орж байгаа зорилго, хүлээлт, ажлаас гарч байгаа учир шалтгаан г.м )-ийн талаарх мэдээлэл зайлшгүй шаардлагатай байдаг.

Иймд 2021 онд байгууллагын бүх ажилтнуудын стрессын түвшинг тогтоолгох судалгааг үнэлгээний багийн зүгээс хийх болсон.

*Ажилтны сэтгэл ханамжийн түвшин*

Ажилтнууд юу хийж байна (ажил үйлчилгээ), яаж түүнийгээ хийж байна (зан үйл, хандлага), юунд хүрч байна (үр дүн) гэдгийг хамтад нь авч үздэг байна. Ажилтны зан үйл, хандлага бол түүний ажлын сэтгэл ханамжаар илрэн гардаг.

Ажлын сэтгэл ханамж гэдэг нь ажлын үр дүнгээс шалтгаалан үүсэх сэтгэл хөдлөлийн ханамжтай ба ханамжгүй байдал юм. Энэ нь ажилтны ажилд хандах хандлага, ажлаасаа хүлээн авч байгаа буюу хүлээн авахыг хүсэж байгаа үр дүнгийн хоорондын ялгаанаас бий болдог. Өөрөөр хэлбэл, сэтгэл ханамж ажилчдын цалин, урамшуулал болон тэдний бодлоор авах ёстой гэж бодож байгаа хэрэгцээний түвшний нийлбэрүүдийн хоорондын харьцаагаар тодорхойлогддог (Ц.Цэцэгмаа, 2009).

Сэтгэл ханамж өндөр байх нь ажилчдын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлдөг учир аль болох өндөрт байлгах нь ашигтай юм. Ажилтны сэтгэл ханамжид дараах хүчин зүйлс нөлөөлдөг.




Эдгээр хүчин зүйлсээс цалин урамшуулал, ажлын орчин, удирдлагын арга барил, хамт олон гэсэн шалгуураар санал асуулгын анкет бэлдсэн.

Судалгаанд оролцсон ажилтныг 1. Улсын өмгөөлөгч 2. Ажлын албаны ажилтан гэж ангилсан.

1. Улсын өмгөөлөгч

Улсын өмгөөлөгчөөс сэтгэл ханамжийн судалгаа авахдаа өмнөх 3 жилийн сэтгэл ханамжид өөрчлөлт гарсан эсэхийг тогтоохыг зорьсон.

Цалин хөлс, урамшууллын тухайд:

**Хүснэгт 57. Цалин хөлс урамшуулал өссөн**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | үгүй | 27 | 49.1 | 49.1 | 49.1 |
| | дунд зэрэг | 14 | 25.5 | 25.5 | 74.5 |
| | тийм | 11 | 20.0 | 20.0 | 94.5 |
| | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | 3 | 5.5 | 5.5 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын цалинг Хууль зүйн туслалцааны төвийн захирлын 2020 оны “Төвийн албан хаагчдын цалинг шинэчлэн батлах тухай” А/01 дүгээр тушаалаар нэмсэн. Тийм гэж хариулт өгсөн өмгөөлөгчдийн хувьд энэ жил цалинд тодорхой хэмжээгээр өөрчлөлт гарч нэмэгдсэн боловч нэг өмгөөлөгчийн авч буй цалин, ачаалал хоёртой урвуу хамааралтай болохыг тайлбарлаж байв.

Ахлах улсын өмгөөлөгч төрийн үйлчилгээний ТҮ-10 шатлалаар буюу 848856–924695 төгрөг, улсын өмгөөлөгч ТҮ-9 шатлалаар буюу 784647–895945 төгрөг, улсын өмгөөлөгчийн туслах ТҮ-4 шатлалаар буюу 524696–590937 төгрөгийн цалинд дүйцүүлэн баталсан.

Улсын өмгөөлөгчийн сарын цалинг дунджаар 860000 /төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн ТҮ-10, ТҮ-9 ангиллын дундаж/ төгрөг гэж үзвэл уг цалингаас нийгмийн даатгал, өмгөөлөгчийн татвар, хариуцлагын даатгал зэргийг төлж, гар дээр ирэх цалин 650000 төгрөг байна.

Мөн улсын өмгөөлөгч ажил үүргээ гүйцэтгэхдээ харилцаа холбоо, унааны зардлыг өөрөөсөө гаргадаг бөгөөд яаралтай үед цагдан хорих, шүүх, цагдаа, прокурорын байгууллага руу очих, шүүх хуралдаан, мөрдөн байцаалтад оролцох зэрэгт нийтийн тээвэр болон таксигаар ажил үүргээ гүйцэтгэдэг.

Улсын өмгөөлөгч нь үндсэн цалингаас гадна нэмэгдэл хөлс, нөхөх олговор авдаггүй тул Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчид олгодог нэмэгдэл цалин хөлсний жишгээр өдрийн хоол, нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийг 1 өдрийн 5500 төгрөг байхаар тооцвол сард 121000 төгрөгийг мөн дээрх цалингаасаа зарцуулж, гар дээр авах цалин нь сардаа 529000 төгрөг байна.

Харин Холбооны өмгөөлөгчдийн хувьд хамгийн бага түвшинд дунджаар нэг хэрэгт нэг сая төгрөг авдаг байна.

Цалин, хөлс, шагнал, урамшууллын ёс зүйн үүрэг нь хуулийн байгууллагуудын хувьд ач холбогдлын түвшин өндөртэй юм. Хүний амь амьдралтай холбоотой чухал шийд гаргах үүрэгтэй албан хаагчийн хувьд цалин хөлсний хэмжээ өндөр байснаар ёс зүйн өндөр түвшинд ажиллах шаардлага тавигдаж, хүний нөөц бүрдүүлэлтийн шалгуурыг өндөрсгөж чадварлаг боловсон хүчнийг шинээр авах, хуучин чадварлаг ажилтнаа тогтоон барих гол хүчин зүйл болдог. Өнөөгийн зах зээлийн хэрэгцээнд улсын өмгөөлөгчийн цалин хөлс хүрэлцэхгүй нөхцөл байдал нь улсын өмгөөлөгч төрийн албанд төрийн чиг үүргийн хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч ижил түвшний албан хаагчтай адил цалин, шагнал, урамшууллыг авч чадахгүй байгаа нь улсын өмгөөлөгчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, үйлчилгээний чанарыг сайжруулах, тэдний цалин, урамшууллыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлж бусад хуульчдын цалингийн жишигт ойртуулах хэрэгцээ шаардлагыг үүсгэж байна.

Улсын өмгөөлөгчийн цалинг шүүн таслах ажиллагааны бусад оролцогчийн түвшинд тогтоох нь төрөөс үзүүлж буй хууль зүйн туслалцааг

чанаргүй, хүндээ хүргэж сэтгэл гаргахгүй ажилладаг гэх шүүмжлэлийг багасгах, өндөр ёс зүйтэй, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэхэд чухал хүчин зүйл болно.

Ажиллах орчин:

**Хүснэгт 58. Ажлын орчин тав тух сайжирсан**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | үгүй | 15 | 27.3 | 27.3 | 27.3 |
| | дунд зэрэг | 26 | 47.3 | 47.3 | 74.5 |
| | тийм | 13 | 23.6 | 23.6 | 98.2 |
| | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | 1 | 1.8 | 1.8 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 59. Ажлаа хийхэд шаардагдах техник хэрэгсэл, унаа, томилолтын хангамж сайжирсан**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | үгүй | 15 | 27.3 | 27.3 | 27.3 |
| | дунд зэрэг | 20 | 36.4 | 36.4 | 63.6 |
| | тийм | 19 | 34.5 | 34.5 | 98.2 |
| | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | 1 | 1.8 | 1.8 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

*Ихэнхи* аймаг, нийслэл, сум, дүүрэгт өөрийн гэсэн байргүй, Засаг даргын Тамгын газрын харьяанд байрладаг байна. Энэ оны 9 сараас эхлэн 3 дүүргийн улсын өмгөөлөгч нар Төвийн захиргааны байранд иржээ. Харьяа бүхий Засаг дарга нар дэмжлэг үзүүлэх үүрэгтэй боловч Засаг дарга нар харилцан адилгүй байна. Үнэлгээний багийнхан Хан-Уул дүүрэгт ажиглалт хийх замаар очиж судалсан болно. Нэг 20 мерт хүрэхгүй жижиг өрөөнд улсын гурван өмгөөлөгч, нэг туслахтайгаа ажиллаж байна. Ковид гарахаас өмнө өдөр дунджаар 10-15 хүн үйлчлүүлдэг гэж захиргааны ажилтан хэлж байв.

Ажлын унаа нь төсвөөс шалтгаалан шинэчлэгдээгүй, хүртээмжгүй тул улсын өмгөөлөгч болгон ашиглах боломжгүй. Иймд улсын өмгөөлөгчид нийтийн тээврээр зорчих, үүнээс шалтгаалан үйлчлүүлэгчтэйгээ уулзах цагаас хоцрох явдал гардаг байна.

**Хүснэгт 60. Ажлын байрны стресс буурсан**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | үгүй | 11 | 20.0 | 20.0 | 20.0 |
| | дунд зэрэг | 24 | 43.6 | 43.6 | 63.6 |
| | тийм | 18 | 32.7 | 32.7 | 96.4 |
| | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | 2 | 3.6 | 3.6 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

Энэ асуултад 70 гаруй хувь нь эерэг хариулт өгсөн. Гэхдээ тусгайлан бэлдсэн сорилоор шалгах ёстой.

Удирдлагын арга барил:

**Хүснэгт 61 . Удирдлагын арга барил сайжирсан**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | үгүй | 5 | 9.1 | 9.1 | 9.1 |
| | дунд зэрэг | 15 | 27.3 | 27.3 | 36.4 |
| | тийм | 31 | 56.4 | 56.4 | 92.7 |
| | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | 4 | 7.3 | 7.3 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 62. Эерэг харилцаа, хандлага сайжирсан**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | үгүй | 6 | 10.9 | 10.9 | 10.9 |
| | дунд зэрэг | 7 | 12.7 | 12.7 | 23.6 |
| | тийм | 41 | 74.5 | 74.5 | 98.2 |
| | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | 1 | 1.8 | 1.8 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

Энэ оны эхээр захирал өөрчлөгдөж, оронд сэлгэн ажиллахаар хүн томилогдон хэсэг ажиллаж байгаад 9 сараас шинэ захиралтай болсон байна.

Төвийн захиралд одоогийн хуульд тодорхой шаардлага байхгүй байна. Төвийн захирлыг зөвхөн захиргааны албан хаагч гэж тодорхойлоод орхих нь учир дутагдалтай юм. Энэ хүн шүүн таслах ажиллагааны нэг хэсэг улсын өмгөөлөгч

нарыг тэргүүлдэг тул түүний эрх зүйн байдлыг хуульд тодорхой шаардлага нь тавих зүйтэй болов уу.

*Захиргааны ажилтны сэтгэл ханамж*

Төвийн ажлын алба буюу захиргааны нийт 10 ажилтнаас санал авахаар төлөвлөсөн ба санал асуулгын анкетыг 7 албан хаагч бөглөсөн.

Цалин хөлс:

**Хүснэгт 63. Би цалиндаа сэтгэл хангалуун байдаг**

| Би цалиндаа сэтгэл хангалуун байдаг | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
| Valid | Огт санал нийлэхгүй байна. | 1 | 14.3 | 14.3 | 14.3 |
| | Санал бараг нийлэхгүй байна | 1 | 14.3 | 14.3 | 28.6 |
| | Дунд зэрэг | 2 | 28.6 | 28.6 | 57.1 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 3 | 42.9 | 42.9 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу мэргэжилтэн ТЗ-5-5-аар 791532, ахлах мэргэжилтэн ТЗ-6-5-аар 853375 байна.

**Хүснэгт 64. Миний ажлын гүйцэтгэлийн үр дүнд тохирсон цалин урамшуулал өгдөг**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
| Valid | Огт санал нийлэхгүй байна. | 1 | 14.3 | 14.3 | 14.3 |
| | Дунд зэрэг | 4 | 57.1 | 57.1 | 71.4 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 2 | 28.6 | 28.6 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2019 оны "Аргачлал, загвар батлах тухай" 47 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын дагуу төрийн захиргааны 4 албан хаагчтай 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж, хянажээ.

**Хүснэгт 65. Бусад төрийн байгууллагатай харьцуулахад миний цалин боломжийн гэж боддог**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Огт санал нийлэхгүй байна. | 1 | 14.3 | 14.3 | 14.3 |
| | Дунд зэрэг | 5 | 71.4 | 71.4 | 85.7 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 1 | 14.3 | 14.3 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

Ажлын орчин:

**Хүснэгт 66 . Өрөө тасалгааны тоо хүрэлцээтэй байдаг**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Дунд зэрэг | 2 | 28.6 | 28.6 | 28.6 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 5 | 71.4 | 71.4 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 67. Ажлаа хийж гүйцэтгэхэд хүрэлцэхүйц техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байдаг**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Дунд зэрэг | 1 | 14.3 | 14.3 | 14.3 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 4 | 57.1 | 57.1 | 71.4 |
| | Бүрэн санал нийлж байна. | 2 | 28.6 | 28.6 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 68 . Ажлын өрөөнд дуу шуугиан багатай байдаг**

| | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Valid | Ерөнхийдөө санал нийлж байна | 6 | 85.7 | 85.7 | 85.7 |
| | Бүрэн санал нийлж байна. | 1 | 14.3 | 14.3 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

Ажлын орчны хувьд ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшин өндөр хувьтай байна. Энэ онд хуучин байрнаас шинэ байрлалд бие даан гарсан учраас энэ үзүүлэлт өмнөх 2018, 2019 оны үнэлгээнээс дээшилсэн байна.

Удирдлагын арга барил:

**Хүснэгт 69. Удирдлага, нэгжийн дарга нар чадварлаг тул би сэтгэл ханамжтай ажилладаг**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Санал бараг нийлэхгүй байна | 3 | 42.9 | 42.9 | 42.9 |
| | Дунд зэрэг | 2 | 28.6 | 28.6 | 71.4 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 2 | 28.6 | 28.6 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 70. Удирдлага, нэгжийн дарга нар миний ажлын гүйцэтгэлийг шударга дүгнэдэг**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Санал бараг нийлэхгүй байна | 3 | 42.9 | 42.9 | 42.9 |
| | Дунд зэрэг | 1 | 14.3 | 14.3 | 57.1 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 2 | 28.6 | 28.6 | 85.7 |
| | Бүрэн санал нийлж байна. | 1 | 14.3 | 14.3 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 71 . Удирдлага, нэгжийн дарга ёс зүй, зан харилцааны хувьд өндөр түвшинд байдаг**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Огт санал нийлэхгүй байна. | 1 | 14.3 | 14.3 | 14.3 |
| | Санал бараг нийлэхгүй байна | 4 | 57.1 | 57.1 | 71.4 |
| | Дунд зэрэг | 1 | 14.3 | 14.3 | 85.7 |
| | Бүрэн санал нийлж байна. | 1 | 14.3 | 14.3 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 72. Миний сурч хөгжих, боломж, нийгмийн асуудлыг шийдэж өгдөг.**

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Огт санал нийлэхгүй байна. | 2 | 28.6 | 28.6 | 28.6 |
| | Санал бараг нийлэхгүй байна | 2 | 28.6 | 28.6 | 57.1 |
| | Дунд зэрэг | 3 | 42.9 | 42.9 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

Байгууллагын уур амьсгал:

**Хүснэгт 73. Хамт олондоо би сэтгэл хангалуун байдаг**

| Хамт олондоо би сэтгэл хангалуун байдаг | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
| Valid | Санал бараг нийлэхгүй байна | 1 | 14.3 | 14.3 | 14.3 |
| | Дунд зэрэг | 2 | 28.6 | 28.6 | 42.9 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 3 | 42.9 | 42.9 | 85.7 |
| | Бүрэн санал нийлж байна. | 1 | 14.3 | 14.3 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 74. Бид биенээ дэмжин ажилладаг**

| Бид биенээ дэмжин ажилладаг |
|---|

| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
|---|---|---|---|---|---|
| Valid | Санал бараг нийлэхгүй байна | 1 | 14.3 | 14.3 | 14.3 |
| | Дунд зэрэг | 2 | 28.6 | 28.6 | 42.9 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 3 | 42.9 | 42.9 | 85.7 |
| | Бүрэн санал нийлж байна. | 1 | 14.3 | 14.3 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

**Хүснэгт 75. Маргаантай асуудлыг бид гомдол өгөх шатанд хүргэдэггүй**

| Маргаантай асуудлыг бид гомдол өгөх шатанд хүргэдэггүй . | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
| Valid | Дунд зэрэг | 1 | 14.3 | 14.3 | 14.3 |
| | Ерөнхийдөө санал нийлж байна | 5 | 71.4 | 71.4 | 85.7 |
| | Бүрэн санал нийлж байна. | 1 | 14.3 | 14.3 | 100.0 |
| | Total | 7 | 100.0 | 100.0 | |

Сургалт хөгжлийн талаар нээлттэй асуулт тавьсан. Энэ жилийн нөхцөл байдлаас шалтгаалан өмнөх жилүүдэд орон нутаг, нийслэлийн улсын өмгөөлөгчдийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 1 удаа цуглуулж, 3-5 хоногт хийдэг байсан. Харин энэ жилийн хувьд цар тахалаас шалтгаалан өмгөөлөгчдийн үргэлжилсэн сургалтыг МХХ-той хамтран 3 хоногийн вебинар сургалтыг зохион байгуулсан.

Мөн 9 сард "Иргэдийн оролцоо" төслийн хүрээнд зөвхөн нийслэлийн албан хаагчдын дунд явуулсан 2 хоногийн сургалт болсон.

**Хүснэгт 76 . Сургалтад тогтмол хамрагдснаар ур чадвар дээшилсэн**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Frequency | Percent | Valid Percent | Cumulative Percent |
| Valid | үгүй | 2 | 3.6 | 3.6 | 3.6 |
| | дунд зэрэг | 22 | 40.0 | 40.0 | 43.6 |
| | тийм | 29 | 52.7 | 52.7 | 96.4 |
| | өмнө нь санал асуулгад орж байгаагүй. | 2 | 3.6 | 3.6 | 100.0 |
| | Total | 55 | 100.0 | 100.0 | |

Санал:

1. Дотоод зохион байгуулалтын бүтцийг боловсронгуй болгосноор ажлын ачааллыг жигдрүүлэн бүтээмжийг дээшлүүлэх
2. Албан тушаалын тодорхойлолтыг боловсронгуй болгох замаар ажлын хуваарилалт, хариуцлагыг сайжруулах
3. Сургалтын хэрэгцээг тодорхойлох үйл явцыг сайжруулах илүү, бодитой болгох

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ДҮГНЭЛТ

**Бодлогын зөвлөмж:**

Хууль зүйн туслалцааны төвийг байгууллагыг төрийн байгууллагын статусаар ажиллуулахыг төр хүсч байгаа бол шүүн таслах ажиллагааны бусад хоёр тал болох шүүх, прокурорын байгууллагаас төвийн эрх зүйн байдлыг нь дордуулахгүй авч явах үүрэгтэй гэж үзэж байна. Хэдийгээр өмгөөллийн үйлчилгээ нь Үндсэн хуулийн хүн өөрийгөө өмгөөлөх эрхийн сонголтын хүрээнд хэрэгждэг ч төлбөрийн чадваргүй иргэдийн хувьд энэ эрхээ эдлэх боломжгүй байдаг. Үндсэн хуулиндаа хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлуулах үүрэгтэй төрийн чиг үүрэгт яах аргагүй эдгээр иргэдийн эрхийг хангах ажил байх ёстой.

Өнөөгийн нөхцөл байдалд ядуурлын хамралтын хүрээ хөдөөд 30.8 хувь, хотод 27.2 хувь буюу хөдөөд хотоос өндөр хэвээр байгаа болович нийт хүн амын гуравны хоёр нь хотод амьдардаг тул нийт ядуу хүн амын арван хүн тутмын зургаа нь эдүгээ хот сууринд амьдарч байна[13].

Үндэсний хэмжээнд ядуурлын түвшин 2016 оны 29.6 хувиас 2018 онд 28.4 хувь хүртэл ялимгүй буурсан байна. Үүний зэрэгцээ хүн амын 15 хувь ядуурлын шугамаас дөнгөж дээгүүр амьдарч байгаа ба гэнэтийн хямралт үйл явдлын нөлөөгөөр ядууралд халтиран орох эрсдэлд байна гэж 2018 оны тайланд бичиж байв. Харин 2020 онд гарсан ковид-19 цар тахлын хувьд ядуурлын хувь ихсэх төлөвтэй байна. 2017 онд Удирдлагын академиас хийсэн Нийгмийн дунд давхрааны төлөв байдал: Улаанбаатар хотын өрхийн жишээгээр” судалгаанд дундаж давхарга гэж тооцогдсон өрхийн 60 гаруй хувьд цалингийн болон бусад зээлтэй, жижиг дунд үйлдвэрлэл эрхэлдэг, төрөөс халамж үйлчилгээ авдаггүй хэсэг бөгөөд тэднээс гэнэтийн огцом эдийн засгийн болон бусад өөрчлөлт бий болвол ядуурлын шугам руу 6,6 хувь нь орох магадлалтай гэж дүгнэж байжээ.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2020 онд гаргасан тайлангуудад[14]: Ихэвчлэн бүртгэлгүй жижиг аж ахуйн нэгжүүд, тэд ихэнхдээ арваас доош албан ёсны бүртгэлгүй, мэргэжлийн ур чадвар багатай, түүнчлэн цалингүй гэр бүлийн, гол төлөв эмэгтэй ажилчид байдаг ба ажлын бүтээмж, хадгаламж, хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө хуримтлал нь тун бага байдаг бөгөөд энэ нь тэд нарыг эдийн засгийн гэнэтийн цочролд илүү өртөмтгий болгодог, мөн КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор жижиг дунд бизнес

[13] Ядуурлын дүр төрх -2018. ҮСХ, Дэлхийн банк
[14] Олон улсын хөдөлмөрийн байгууллагын сайт руу орж танилцана уу. www.ilo.org

эрхлэгчдэд олгох богино хугацааны санхүүгийн тусламжийн хөтөлбөрт тэд хамрагдахгүй байх тохиолдол ч элбэг байдаг. Иймд эдгээр бүлэг иргэд ядуурлын доод шугам руу орох төлөв ажиглагдаж эхэллээ гэж тайландаа дурдсан байна.

ҮСХ-ны мэдээлснээр, улсын хэмжээнд 177,7 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй боловч үүний тал нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад гэхэд 2019 оны эхний 11 сард ажилгүй 76.9 мянган иргэн шинээр бүртгүүлжээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 35.2 хувь нь нийслэлд амьдарч байна.

Гэмт хэргийн үйлдэх шалтгаан, нөхцөлд ядуурал, ажилгүйдэл нэг хүчин зүйлс болдогийг үе үеийн судалгаа харуулдаг. ЦЕГ-аас сар бүр гаргадаг гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн тоон мэдээлэлд тухайлбал, 11 сард нийт гэмт хэрэг үйлдсэн 15454 хүнээс ажилгүй 8017 хүн буюу 60 –ээс дээш хувь эзэлж байна. Эдгээр ажилгүй хүмүүсээс төлбөрийн чадваргүй гэж өрхийн мэдээллийн санд бүртгэгдсэн байхаас гадна өөрийгөө тодорхойлсон хүмүүсийн дийлэнх улсын өмгөөлөгчийн туслалцаа авдаг байна (тайлангийн 1.1 –ээс харна уу). Иймд төлбөрийн чадваргүй иргэдэд үзүүлэх улсын өмгөөлөшчйн ачаалал ойрын таван жилд өнөө байгаа түвшингээс буурахгүй байх төлөв эхний байдлаар ажиглагдаж, цаашид Ковидын нөхцөл байдал даамжирвал тодорхой хэмжээгээр нэмэгдэхээр болж байна.

Гэтэл төлбөрийн чадваргүй гэмт хэрэг холбогдсон хүмүүст үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хангалтгүй байгааг иргэд, хууль сахиулах байгууллагын албан хаагчид шүүмжилдэг (өмнөх хэрэглэгчийн үнэлгээний тайлангуудыг харна уу). Энэ нь нэг талаас тухайн улсын өмгөөлөгчийн мэдлэг, ур чадвараас шалтгаалах боловч, нөгөө талаас улсын өмгөөлөгчдийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэх боломж, цалиндаа сэтгэл ханамжтай ажиллах, ачаалал тэнцвэртэй байх зэрэг нь тогтолцооноос шалтгаалж хангалтгүй байгаа тул улсын өмгөөлөгчдийг шууд муу байна гэж дүгнэж болохгүй. (тайлангаас улсын өмгөөлөгчийн ачаалал, цалингийн талаар мэдээлэл авна уу)

Зөвлөмж:

1.Хууль зүйн туслалцааны төвийн эрх зүйн байдлыг төрийн байгууллагын статусаар хэвээр авч үлдэх ёстой гэж үзэж байгаа бол шүүх, прокурорын байгууллагын албан хаагчийн цалин, нийгмийн баталгааны түвшинд хүргэх, тухайлбал төрийн тусгай албан хаагчаар улсын өмгөөлөгчийг тооцох, ажлын

албаны албан хаагчдын зэрэглэлийг дээшлүүлэх, эрх зүйч мэргэжилтэй ажлын албаны албан хаагчдын тоог нэмэх

2. Хэрэв төсөвт хүндрэлтэй гэж үзвэл Хууль зүйн туслалцааны төвийг бие даан аж ахуйн тооцоотой, ХЗДХЯ-тай менежментийн гэрээгээр ажилладаг, Өмгөөллийн болон Хуульчдын холбоонд хамаарах нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг төвлөрүүлэн зангиддаг байгууллага болгон статусыг өөрчлөх, мөн төлбөрийн чадваргүй иргэдэд гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажил хийх, энэ хүрээнд Үндэсний хөтөлбөрүүдээс санхүүжилт авах, НҮБ бусад олон улсын байгууллагатай хамтарч ажилах, хандив, тусламж авах зэрэгт нээлттэй ажиллах, төлбөрийн чадваргүй хүмүүсийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гаргахаас сэргийлсэн үйлчилгээний тоо , чанарын үзүүлэлтэд тохирсон татварын хөнгөлөлт, урамшуулал авдаг байх

3. Өмгөөлөгчдийн Холбоо бие даасан хуультай болсон гэж үзвэл улсын өмгөөллийн үйл ажиллагааг харьяанд нь шилжүүлж, төсвөөс үйлчилгээ үзүүлсэн тоогоор санхүүжилт авдаг тогтолцоонд шилжих,

4. Засгийн газраас баталсан "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх Үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө авах (тусгаар дугаар бүхий утас, пэйж хуудас гэх мэт) асуудлыг Хууль зүйн Үндэсний хүрээлэнд төвлөрүүлэх, хууль зүйн туслалцааны хувьд зөвхөн төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг хийх

Хэрэглэгчдийн үнэлгээ хийсэн тухайд байгууллагад өгөх зөвлөмж:

1. Хууль зүйн зөвлөгөөний чиглэлээр төлбөрийн чадваргүй иргэд үйлчилгээ авах талаар хороо, багийн нийгмийн ажилтан, халамж үйлчилгээний ажилтантай хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллах, Жишээлбэл: Хорооны ажилтан тухай хороонд хэдэн төлбөрийн чадваргүй иргэд байгаа талаар тухай дүүрэгт ажиллаж буй улсын өмгөөлөгчид жилийн эхний 1 сарын дотор мэдээлэх, энэ дагуу улсын өмгөөлөгч ажлаа төлөвлөх,
2. Улсын өмгөөлөгчийн утсаар зөвлөгөө өгсний дараа сэтгэл ханамжийн талаар автомат хариулагчаар дүгнэлт өгөх боломжийг техникийн хувьд шийдэх (бодлогын зөвлөмжид бүх иргэдэд утсаар зөвлөгөө өгдгийг болиулах гэж оруулсан)

3. Байгууллагын эрхэм зорилго, стратегийн баримт бичиг, хүний нөөцийн хөтөлбөр батлан ажиллах зэрэг болно.